

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ХХААХҮЯ-ны харьяа Мал хамгаалах сангийн
2011-2017 он, 2018 оны эхний хагас жилийн байдлаар санхүү,
аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тухай

Мал хамгаалах сан нь:

Үндсэн үйл ажиллагаагаа 2009 он хүртэл Тариалан эрхлэлтийг дэмжих сантай хамт, 2009-2011 он хүртэл Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын бүтцэд ажиллаж байгаад, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд бие даан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Сангийн үндсэн зорилго, чиг үүрэг, зорилтууд:

МАА-н салбарт хэрэгжиж буй Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих, Монгол мал зэрэг хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

Бүтэц зохион байгуулалт:

Мал аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд 12 орон тоотойгоор бие даан үйл ажиллагаа явуулж байна.

Зорилтууд:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд техник технологийн болон эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх, зээлийн ашиглалтад хяналт тавих, зээлийг эргэн төвлөрлүүлэх.
2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд техник, тоног төхөөрөмж хөнгөлөлттэй нөхцөлөөр болон түрээсийн гэрээ байгуулан олгох.
3. Мөн дээрхи бүлгийн ААНБ, иргэдэд мал, амьтан хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох дэмжлэг үзүүлэх.
4. Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 394 дүгээр тогтоолоор “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”, “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу урамшуулал олгох.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж:

- Улсын Их Хурлын 30 дугаар тогтоол /“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” /2011оны/
- Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоол /“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай”/
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /2006 он/

Сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх Засгийн газрын тогтоол, холбогдох журам:

- Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолоор баталсан / “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам”/.
- Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоол /”Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журам”/.
- Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоол /”Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам шинэчлэн батлах тухай”/ зэрэг эрхийн актууд мөрдөж иржээ.

Мал хамгаалах сангийн орлогын эх үүсвэр /2016-2018.06.30/

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	2016 он			2017 он			2018.06.30		
	Төлөв	Гүйцэт-гэл	хувь	Төлөв	Гүйцэт-гэл	хувь	Төлөв	Гүйцэт-гэл	хувь
Улсын төсвөөс	29,176.4	28,877.2	99.0	75,353.8	75,353.8	100.0	22,637.2	22,550.8	99.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	2,186.8	1,726.6	79.0	2,213.3	1,545.1	69.8	800.0	882.2	100.0
Нэр данс зөрүүтэй орлого	9.2	9.2	100.0						
Дүн	31,372.4	30,742.7	98.0	77,567.1	76,919.9	99.1	23,437.2	23,433.0	100.0

Мал хамгаалах сангийн 2016, 2017 онуудын болон 2018 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн талаар.

МХСан 2016 онд 30,742.7 сая төгрөг, 2017 онд 76,919.9 сая төгрөгийн, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 23,270.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэртэйгээр тус тус ажилласан байна. Нийтдээ 2016 онд 30,742.7 сая төгрөгийн орлого олсоны 94 хувь буюу 28,877.2 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилт, 0.4 хувь буюу 138.9 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор, 5.6 хувь буюу 1,726.6 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөр, 2017 онд 76,919.9 сая төгрөгийн орлого олсоны 97.9 хувь буюу 75,353.7 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилт, 0.2 хувь буюу 36.2 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлого, 1.9 хувь буюу 1,530.0 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлт, 2018 оны эхний хагас жилд олсон 23,270.0 сая төгрөгийн 96.9 хувь буюу 22,550.8 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 1.2 хувь буюу 22.6 сая төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд буй болсон нэмэлт орлогоор, 3.0 хувь буюу 692.4 сая төгрөгийг хөрөнгийн орлогоор тус тус бүрдүүлжээ.

2016 онд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 39.8 сая төгрөг, 2017 онд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 410.7 сая төгрөгийг Сангийн яамны Төрийн санд оны эцэст татан төвлөрүүлсэн байна.

Зардлын үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 он			2017 он			2018.06.30		
	Төлөв	Гүйцэт-гэл	хувь	Төлөв	Гүйцэт-гэл	хувь	Төлөв	Гүйцэт-гэл	хувь
НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛ ДҮН	31,363.2	30,453.1	97.1	77,567.1	79,916.7	99.2	23,621.9	23,167.6	98.1
Нийт зарлагын дүн	29,454.2	28,899.1	98.1	35,658.1	35,926.7	100.8	22,821.9	22,520.8	98.7
Бараа, үйлчилгээний зардал	265.6	259.9	97.8	298.4	298.2	99.9	179.8	142.9	79.5
Цалин хөлс, нэмэгдэл урамшил	155.9	155.9	100.0	197.9	197.8	99.9	114.6	87.4	76.3
Үндсэн цалин	142.3	142.3	100.0	136.0	143.4	105.4	78.9	64.9	82.3
нэмэгдэл				19.9	19.9	100.0	100.0	76.4	76.4

	Унаа хоолны хөнгөлөлт	13.6	13.6	100.0	13.5	17.2	127.3	14.5	10.9	75.2
	Гэрээт ажлын хөлс	-	-		28.5	17.3	60.9	-	-	
	АО-оос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17.3	16.9	97.6	21.8	21.8	100.0	10.2	10.9	106.8
	Байр ашиглалттай холбоотой зардал	1.5	1.5	100.0	-	-	-	-	-	-
	Хангамж, бараа материалын зардал	31.3	30.1	96.1	18.8	18.8	100.0	16.2	14.8	91.5
	Бичиг хэргийн материал	6.5	6.2	95.6	4.4	4.5	101.5	3.0	2.7	89.1
	Тээвэр, шатахууны зардал	13.0	12.2	93.6	6.9	6.8	99.5	6.9	6.5	93.4
	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6.8	6.8	100.0	9.9	3.8	99.2	3.9	3.9	100.0
	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	5.0	4.9	98.2	3.6	3.6	100.0	2.2	1.6	72.4
	Нормативт зардал	1.5	1.4	93.2	1.5	1.5	100.0	1.5	-	-
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.5	1.4	93.2	1.5	1.5	100.0	1.5	-	-
	Эд хогшил, урсгал засварын зардал	15.3	11.7	76.4	5.6	5.6	100.0	5.3	3.4	63.4
	Тавилга	6.5	6.2	95.7	5.6	5.6	100.0	5.3	3.4	63.4
	Урсгал засвар	8.8	5.5	62.1						
	Томилолт, зочны зардал	25.1	25.1	100.0	27.5	27.5	100.0	18.7	12.8	68.1
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	12.3	11.9	97.0	25.3	25.2	99.8	13.4	13.8	103.0
	Бараа үйлчилгээний бусад зардал	5.3	5.3	100.0	-	-	-	-	-	-
	Ажил олгогчоос олгох нэг удаа -гийн тэтгэмж, шагнал, урамшуулал	12.2	11.8	97.0	9.6	9.5	99.9	5.0	2.6	52.8
	ТАТААС	29,176.4	28,627.4	98.1	35,350.2	35,618.9	100.8	22,637.2	22,375.3	98.8
	Хувийн хэвшлийн байгуул- лагад олгох татаас	29,176.4	28,627.4	98.1	35,350.2	35,618.9	100.8	22,637.2	22,375.3	98.8
	Эргэж төлөгдөх зээл	1,909.0	1,554.0	81.4	41,909.0	40,990.0	97.8	800.0	646.8	80.8
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	31,372.4	30,742.7	98.0	77,567.1	76,919.9	99.1	23,437.2	23,433.0	100.0
	- Төсвөөс санхүүжих	29,176.4	28,877.2	99.0	75,353.8	75,353.8	100.0	22,637.2	22,550.8	99.6
	-Үндсэн үйл ажиллагааны орлогоос	2,186.8	1,726.6	79.0	2,213.3	1,545.1	69.8	800.0	882.2	100.0
	-Нэр данс зөрүүтэй орлого	9.2	9.2	100.0						

2016 онд батлагдсан нийт төсөвт зардлын 0.6 хувь буюу 155.9 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 0.04 хувь буюу 11.9 сая төгрөг нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 0.005 хувь буюу 1.5 сая төгрөг нь байр ашиглалттай холбоотой зардал, 0.024 хувь буюу 68.3 сая төгрөг нь хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолтын зардал зэрэг бусад зардлууд эзэлж байна.

2017 онд нийт төсөвт зардлын 0.55 хувь нь буюу 197.8 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, 0,07 хувь буюу 25.2 сая төгрөг нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 0.15 хувь буюу 53.3 сая төгрөг нь хангамж, бараа материалын болон нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт болон бусад зардалд тус тус зарцуулжээ.

2018 оны төсвийн гүйцэтгэл нийт дүнгээрээ 99.8 гүйцэтгэлтэй, хэмнэлтэй ажилласан байна. Зардлын нэр төрлөөр авч үзвэл: Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6.8 хувиар буюу 0.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 3.0 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж, бусад 15 нэрийн зардлыг 52.8-100.0 хувийн гүйцэтгэлтэй буюу хэмнэлттэй зарцуулжээ.

Сангийн сайдын 2014 оны 05 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын дагуу авч үзвэл тайлант хугацаанд бүлгийн дүнгээр болон зардлын зүйл тус бүрээр хянагддаг зардлуудын хувьд хэтрэлт гараагүй, нийт батлагдсан

төсвийг 0.1-1.8 хувиар хэмнэж ажилласан нь Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, Сангийн сайдын 2014 оны 122 дугаар тушаалуудын хэрэгжилтийг ханган төсвийн зардлыг хэмнэх, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан ажилласантай холбоотой байна

Мал хамгаалах сангийн авлага, өглөгийн талаар.

Мал хамгаалах сангийн нийт авлагыг 2018 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар харуулбал:

/мянган

төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	НИЙТ АВЛАГА	33,854,033.6	19,512,055.3	8,258,275.7	45,105,580.3
2	Төлбөртэй үйлчилгээний авлага	21,186,309.9	18,813,690.1	7,131,649.2	32,868,350.8
3	Татаас санхүүжилтийн авлага	410,734.0	-	69,856.2	340,877.8
4	Бусад авлага	4,766.9	17,655.5	17,655.5	4,766.9
5	Байгууллагаас авах авлага	3,064.9	16,899.5	16,899.5	3,064.9
6	Бусад зардлын тооцооны авлага	3,064.9	2,951.2	2,951.2	3,064.9
7	Хувь хүмүүсээс авах авлага	1,702.0	756.0	756.0	1,702.0
8	Зээлийн авлага	12,252,222.9	680,763.6	1,041,401.6	11,891,584.9
9	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	12,252,222.9	680,763.6	1,041,401.6	11,891,584.9
10	Зээлийн авлага- МЭММАА33 төслийн зээл	143,902.5	-	5,983.5	137,919.0
11	Зээлийн авлага- ШХХөтөлбөр	188,543.0	-	750.1	187,792.9
12	Зээлийн авлага- ММХөтөлбөр	1,757,177.2	1,790.6	82,934.3	1,676,033.5
13	Зээлийн авлага - МХСангийн зээлийн авлага	438,261.2	-	1,000.0	437,261.2
14	Зээлийн авлага- ЭМААХДХ зээл	9,724,339.0	678,973.0	950,733.7	9,452,578.3

Мал хамгаалах сангийн 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаас үзэхэд: Тайлант жилийн эхэнд нийтдээ 33.9 тэрбум төгрөгийн авлагатай байсан бол 19.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 8.3 тэрбум төгрөг хасагдсанаар нийт авлагын хэмжээ 45.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Авлагын хэмжээ нэмэгдсэн гол шалтгаан нь төлбөртэй үйлчилгээний авлагаар бүртгэсэн Малын тэжээл импортлох аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн 21.2 тэрбум төгрөгийг урьд онд олгож, үлдэгдэл 18.8 тэрбум төгрөгийг дараа онд олгосноос шалтгаалжээ.

Урьд онуудаас дамжсан төсөл хөтөлбөрийн зээлийн нийт авлага оны эхэнд 12.3 тэрбум төгрөг байсан нь 680.8 сая төгрөгөөр нэмэгдэж 1,041.4 сая төгрөгөөр буурч 2018 оны эхний хагас жилийн байдлаар 11.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болжээ.

Хөтөлбөр тус бүрээр нь авч үзвэл: “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслийн зээлийн авлага 143.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол, 6.0 сая төгрөгөөр буурч 137.9 сая төгрөгийн авлагатай, “Шилмэл хээлтүүлэгч” хөтөлбөрийн зээлийн авлага 188.5 сая төгрөгөөс 750,1 мянган төгрөгөөр буурч 187.8 сая төгрөгийн, “Монгол мал” хөтөлбөрийн зээлийн авлага оны эхэнд 1,757.2 сая төгрөг байсан бол 1,790.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 82,934.3 мянган төгрөгөөр хасагдаж 1,676.0 сая төгрөгийн, Мал хамгаалах сангийн зээлийн авлага 438.3 сая төгрөг байснаас 1.0 сая төгрөгөөр хасагдаж, 437,261.2 мянган төгрөгийн, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн зээлийн авлага 9,724.3 сая төгрөг байсан бол 678,973.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 950,733.7 мянган төгрөгөөр хасагдаж 9,452.6 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

2003 оноос хойш иргэн, ААН-д олгосон зээлээс хугацаа хэтэрсэн гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй 3,450.0 сая төгрөгийн зээлийн асуудлыг шүүхэд шилжүүлсэн, 11,891.6 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн эргэн төлөлт оны эхнээс 2.9 хувиар буурсан байна.

ХХААХҮ-ийн сайдын 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/06 тоот тушаалаар нийт 6,5 тэрбум төгрөгийн зээлийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Мал эмнэлэг үржлийн газраас шилжүүлэн авч санхүүгийн тайланд тусгасан байна.

Мал хамгаалах сангийн нийт өглөгийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар харуулав.

		/мян.төгрөгөөр/			
	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	40,035,792.2	1,955,609.5	1,462,577.2	40,528,824.5
2	Өглөг	40,035,792.2	2,064,086.5	1,462,577.2	40,637,301.6
3	Ажилчидтай холбогдсон өглөг	(0.00)	98,778,809.82	98,778,809.82	(0.00)
4	Цалин	(0.00)	71,350,585.03	71,350,585.03	-
5	НДШ	(0.00)	18,489,222.54	18,489,222.54	(0.00)
6	ХАОАТ	-	8,939,002.25	8,939,002.25	0.00
7	Бараа үйлчилгээний зардал	40,000,000.0	-	-	40,000,000.0
8	Бусад зардлын тооцоо	40,000,000.0	-	-	40,000,000.0
9	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	19,807,690.00	-	18,215,800.00	1,591,890.00
10	Бусад өглөг	15,984,509.00	1,856,830,734.40	1,345,582,567.40	527,232,676.00
11	Байгууллагад төлөх өглөг	9,894,999.00	1,856,425,734.40	1,344,877,567.40	521,443,166.00
12	Хувь хүмүүст төлөх өглөг	6,089,510.00	405,000.00	705,000.00	5,789,510.00

Өглөгийн хувьд авч үзэхэд: Малын тэжээл дотооддоо болон үйлдвэрлэх, ОХУ-аас импортлох зориулалтаар аж ахуйн нэгжүүдэд улсын төсвөөс олгосон 2017 оны сүүлчээр олгосон зээлийн өглөг 40.0 тэрбум төгрөгийн өглөг нийт өглөгийн 99.5 хувийг эзэлж төлөх хугацаа 3.5 сараар хэтэрч байна.

2007-2018 онуудад Мал хамгаалах сангаас аж ахуйн нэгж, байгууллага,
иргэдэд иргэдэд олгосон зээлийн дэмжлэгийн талаарх мэдээлэл
/сая төгрөг/

№	Зээл олгосон онууд	Олгосон зээлийн дэмжлэг /сая төгрөг/	Төлвөл зохих /өссөн дүнгээр/	Төлөгдсөн нь /өссөн дүнгээр/	Эцсийн үлдэгдэл	Төлөлт /хувь/
Шилмэл хээлтүүлэгч хөтөлбөрийн хүрээнд						
1	2003	57.9	81.9	6.5	75.4	-
2	2004	87.6	133	7.1	125.9	-
3	2005	105.5	161.1	16.1	145	-
4	2006	24.3	29.5	16.2	13	-
	Дүн	275.3	405.5	45.9	359.6	-
Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр болон Монгол мал хөтөлбөрийн хүрээнд						
5	2007	211.8	211.8	123.5	88.2	58.3
6	2008	120.0	120.0	120.0	-	100.0
7	2009	1,146.0	1,188.3	989.9	204.9	83.3
8	2010	1,153.0	1,272.9	1,053.9	207.7	82.8
9	2011	6,071.1	6,803.6	5,026.7	1,801.8	73.9
10	2012	1,525.5	1,638.5	1,071.1	571.3	65.4
11	2013	2,170.5	2,363.8	1,273.1	1,091.1	53.9
12	2014	1,990.0	1,740.1	1,181.7	960.9	67.9
13	2015	1,274.0	875.6	512.2	870.4	58.5
14	2016	1,554.0	716.4	515.9	1,133.0	72.0
15	2017	990.0	173.0	85.7	925.7	49.5
16	2018	1,248.2	-	-	1,248.2	0
	ДҮН	19,454.0	17,103.9	11,953.7	9,103.2	69.6

Тайлбар: 2007 оноос 2017 оны зээлийн эргэн төлөлт нь 69.6 хувьтай байна

Мал хамгаалах сан бие даан байгуулагдаагүй байх үед Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас болон Тарилан эрхлэлийг дэмжих сан, Мал эмнэлэг үржлийн газарт харъяадаж байх үед олгосон зээлийн анхны гэрээ, төслийн холбогдох санхүүгийн баримтуудыг мал хамгаалах санд байхгүй байна.

Зарим баримтуудыг ХХААХҮЯ-наас авч үзэх шаардлагатай байсан боловч олдохгүй байсан тул одоо ажил хариуцаж буй албан тушаалтнуудаас тайлбар авч баримтад хавсаргахаар шийдвэрлэв.

Ялангуяа 2003-2006 онуудад олгосон зээлийг ихэвчлэн 1 жил, дээд тал нь 3 жилийн хугацаатай олгосон байна.

Гэтэл Мал хамгаалах сан бие даан байгуулагдсанаас хойш шилжүүлж өгсөн 275.3 сая төгрөгийн хүү тооцогдож төлбөл зохих дүн нь харагдахгүй, дахин тооцохын тулд анхны гэрээг нь үзэх шаардлагатай байгаа юм. Энэхүү зээлийн төлөгдсөн дүн, эцсийн үлдэгдлээс харахад төлөгдсөн 45.9 сая төгрөгийг хасаад одоо төлөх зээлийн үлдэгдэл нь анх олгосон зээлээс 84,960.3 мянган төгрөгөөр илүү тооцсон байна.

Онууд	2011 оны эхний үлдэгдэл	Урьд онуудад нөхөн тооцсон зээлийн хүү	Гэрээг үндэслэн шинэчилж тооцсон хүү	Тооцооллын зөрүү нь
2003	57,880,430	24,013,188	11,993,201	12,019,987
2004	87,650,600	45,456,100	17,529,360	27,926,740
2005	105,579,377	52,377,409	10,667,402	41,710,007
2006	24,256,150	5,233,690	1,930,107	3,303,583
Нийт	275,366,557	127,080,387	42,120,071	84,960,316

Мал хамгаалах санд 2011 онд 275.3 сая төгрөгийг шилжүүлж бүртгэсэн байна. Харин 2011 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “Нийслэл аудит”-ын зөвлөмжөөр 2003-2006 онуудад ААНБ, иргэдэд олгосон зээлд урьд онуудад хүү тооцогдоогүй тул “нөхөж хүү тооцох гэсний” дагуу тооцохдоо гэрээнд заасан хугацааг баримтлалгүйгээр 7-10 жилээр үндсэн хүүг тооцож, нийт 127.0 сая төгрөгийн хүүг суулган тооцож, санхүүгийн тайланд тусгасан байна.

Гэвч тус санд байгаа 2003 он болон 2005 оны зээлийн гэрээнээс үзэхэд тухайн онуудад олгож байсан зээлийн дэмжлэг нь 2-3 жилийн хугацаатай байна. Зээлийн 2003-2006 онуудад 57,880,430 төгрөгийн зээл олгосон, одоогийн байдлаар зээлийн үлдэгдэл 75,440,318 төгрөг байна.

Зээлийн хүүгийн тооцооллыг дээр дурьдсан хүснэгтээр гэрээг баримтлан 3 жилээр тооцож дахин хийж харуулав. Зээлдэгчдийн төлбөл зохих зээлийн үндсэн хүүг /гэрээнд/ заасан хугацааг илүү тооцож, авлагаар тусгасан байгаа нь эрх зүйн зөрчил үүсгэсэн байна. Харин гэрээнд зааснаар зээлийг төлбөл зохих хугацааг хэтэрүүлсний алдангийг тооцож нэхэмжлэл гаргах ёстой.

Иймд холбогдох материалыг бүрдүүлэн шүүхэд нэхэмжлэл гаргаж зээлийг төлүүлэх, үндэслэлгүй тооцсон 84,960,316 төгрөгийн хүүгийн төлбөрийг чөлөөлөх шийдвэр гаргуулах шаардлагатай байна. Мал хамгаалах сангаар дамжуулан “Шилмэл хээлтүүлэгч дэд хөтөлбөр”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”, “Монгол мал хөтөлбөр”-ийн хүрээнд 2003-1018 онд нийт 27,079.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнээс өнөөдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 15,812.8 сая төгрөг байгаагаас 6,350.0 сая төгрөг нь мал амьтнаар олгосон зээл байна.

Дээр дурьдсан зээлийн 5,974.6 сая төгрөгийн зээл нь хугацаа хэтэрсэн, 9,838.2 сая төгрөг нь хугацаандаа байгаа зээл юм. Хугацаа хэтэрсэн зээлийн 1,200.0 сая төгрөг нь “Гацуурт” ХХК-иас авах 104 толгой үхэр, 450.0 сая төгрөг нь “АТААСҮ” ХХК-иас эргэн төвлөрөх Альпень үүлдрийн 200 толгой ямаа, үлдсэн 4,324.6 сая төгрөг нь мөнгөөр эргэн төвлөрөх зээл байна.

Хугацаа хэтэрсэн мөнгөн зээл, түүний насжилтын талаар:

2003-2006 онд олгосон 359.6 сая төгрөгийн зээл нь 9-15 жил болсон бөгөөд шүүхэд нэхэмжлэл гаргахад материал дутуу, баримт бичгийн бүрдэл дутуу, хөөн хэлэлцэх хугацаа дууссан зэргээс шалтгаалан шүүх хүлээн аваагүй байна. Харин 2007-2013 онд олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 3-9 жил болсон зээлийн үлдэгдэл 3,965.0 сая болсон нь 1,201.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 9,658.2 сая төгрөгөөр буурсан байна. Энэхүү хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 3,965.0 сая төгрөг нь 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар 83 иргэн, аж ахуйн нэгжийн 1,710.3 сая төгрөг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, 4 иргэн аж ахуйн нэгжийн 62.5 сая төгрөг нь шүүхийн шатанд, 15 иргэн аж ахуйн нэгжийн 355.8 сая төгрөг нь эрэн сурвалжилж байгаа, 7 иргэн аж ахуйн нэгжийн 57.8 сая төгрөг нь шүүхийн шийдвэр гарсан төлөгдөж байгаа, шүүхээс хаягандаа байхгүй гэсэн шалтгаанаар буцсан 31 иргэн аж ахуйн нэгжид холбогдох 425.8 сая төгрөгийн авлагыг хаяг, байршлыг тогтоож, шүүхэд нэхэмжлэл гаргах чиглэлээр ажиллаж байна.

Мал амьтнаар эргэн төлөх нөхцөлтэй олгосон зээл

/сая.төгрөг/

№	Аж ахуйн нэгжийн нэр	Зээл авсан он	Олгосон зээлийн дүн	Төлбөл зохих зээл /өссөн дүнгээр/	Төлсөн дүн /өссөн дүнгээр/	Зээлийн үлэгдэл	Төлөлт /хувь/
1	Гацуурт ХХК	2011	1,000.0	1,000.0	1,000.0	-	100
2	Гацуурт ХХК	2013	2,000.0	1,200.0	-	2,000.0	-
3	АТААСҮ ХХК	2013	450.0	450.0	-	450.0	0
4	Бага-өлгий ХХК	2014	300.0	150.0	150.0	150.0	100
5	Тайшир өргөө ХХК	2017	1,600.0	-	-	1,600.0	0
6	Газар агро ХХК	2017	1,000.0	-	1,000.0	-	100
7	Сэлэнгэ тариа ХХК	2017	1,000.0	-	-	1,000.0	
Нийт дүн			7,350.0	2,800.0	2,150.0	5,200.0	76.8

“Монгол мал” хөтөлбөр болон “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, Мал хамгаалах сангаас зээлийн эргэн төлөлтөөс олгосон зээлийн эргэн төлөлтийн хувь нилээд доогуур байгаа нь хөтөлбөрийн болон талуудын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт төдийлөн сайн биш, талууд байгуулсан гэрээгээ тогтоосон хугацаанд нь дүгнэдэггүй, зээлдэгч нартай харьцах эргэх холбоо, харилцаа, яам болон Мал хамгаалах сангийн ажлын уялдаа хангалтгүй байгаатай холбоотой байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам бодлоготойгоо уялдуулж байгаа гэдгээр бүх сонгон шалгаруулалтыг Мал хамгаалах сангаас төлөөлөл оролцуулалгүйгээр зохион байгуулдаг, улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа, хөрөнгө оруулалт, зээл, дэмжлэгийг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцаар санхүүжүүлдэг, анхдагч эх үүсвэрийг гаргаж байгаа гэдгээр зээл дэмжлэгийг ямар аж ахуйн нэгж иргэнд олгохыг ХХААХҮЯ шийдвэрлэж, тус яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, мал аж ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн зэрэг албан тушаалтнууд гэрээний нэг тал болж /бодлогын/ гэрээг байгуулж байгаа боловч, төсөл хөтөлбөрийн болон зээл, дэмжлэгийн гүйцэтгэл, үр дүнг нэгтгэн дүгнэх, зээл дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэх, эргэн төлөлт зэрэгт тавих хяналт шаардлагын хэмжээн хүрэхгүй байна.

ББСБ-аар дамжуулан 2005 онд олгосон зээлийн гэрээний үүрэг зөрчигдөж, өнөөг хүртэл зээлийн үлдэгдэлтэй, эргэн төлөлт хангалтгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 169 тоот тушаалын хавсралтад заасан 34 аж ахуйн нэгжид олгох 1-1.5 жилийн хугацаатай 2.0-10.0 сая төгрөгийг хуваарилж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт зориулан Мал хамгаалах сангаас /900019040/ тоот харилцах данснаас “Праймлайнс” ББСБ-ын регистр-5018218 дугаартай, 1102834958 тоот дансанд 187.0 сая төгрөгийг шилжүүлжээ.

Энэхүү зээлийн үйлчилгээг үзүүлэх ББСБ-ыг сонгох тухай, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захирал Ч.Пэрэнлэй товч танилцуулахдаа: Өмнө нь олгосон зээлийг ХААН банкаар дамжуулан олгосон, зээлийн тал нь олгогдохгүй байна. 1.2 хувийн хүү зээлийн

ашиглалт, төлөлтийг хянах шалгах зардалд хүрэлцэхгүй байгаа, нөгөө талаар төслийг бизнесийн зээлтэй адилтган үзэж, богино хугацаагаар өгөх, хүүг сар бүр тооцож авахаар, мөн зээлийг эхний сараас эхлэн төлүүлэхээр гэрээ хийж байгаа нь ХАА-н салбарын чиглэлтэй төсөл хэрэгжих боломжгүй болгож байгаа тухай олон гомдол санал, төсөл хэрэгжүүлэгчдээс ирсэн, банк ч жижиг зээлийг сонирхохгүй байна гэжээ.

Энэ шийдвэрийн дагуу 2005 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “Зээлийн үйлчилгээ үзүүлэх тухай ЗҮ-2005/1 дугаартай гэрээг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захирал Ч.Пэрэнлэй, нөгөө талаас 9015001008 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5018218 тоот регистрийн дугаартай “ПРАЙМЛАЙНС” ББСБ-ын Гүйцэтгэх захирал Х.Гансүх нар гэрээ байгуулж, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 169 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, Зээлийн үйлчилгээ үзүүлэх гэрээг 2005 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 2007 оны 7 дугаар сарын 01 хүртэл 1 жил, 6 сарын хугацаагаар байгуулжээ. Гэрээний ерөнхий нөхцөлийн 1.4-д Гэрээний хугацаа дуусмагц эх үүсвэрийг буцаан Мал хамгаалах санд шилжүүлж, төлбөрийн тооцоогүй болж, хоёр тал гэрээг дүгнэснээр гэрээ дуусгавар болно.

“Сангийн хүлээх үүрэг” гэсэн хоёр дахь хэсгийн 2.1-д Энэхүү гэрээ хийснээс хойш ажлын гурван өдөрт багтаан 187.0 сая төгрөгийг ББСБ-ын нэхэмжлэлийг үндэслэн Голомт банк дахь 110 283 4958 тоот дансанд шилжүүлж, төслүүдийн хамт өгөхөөр, 2.4-д Сан зээлийн хүүг өгөхгүй бөгөөд хүүг ББСБ-ын үйлчилгээний зардал болон зээлийн эрсдэлд зориулан олгоно.

Гэрээний гурав дахь хэсгийн 3.4-д Зээлийн хүү жилийн 12 хувь байх бөгөөд уг хүүг ББСБ авна, Мөн зээлдэгчдээс төслийн зээлийн дүнгийн нэг хувиар үйлчилгээний шимтгэл авна.

Гэтэл энэхүү банк бус санхүүгийн байгууллагатай хийсэн гэрээний үр дүнг дүгнэж актаар баталгаажуулаагүй, тус санд зээлдэгчидтэй хийсэн зээлийн гэрээний хувь болон зээл олгосон баримтууд байхгүй тул, зээлдэгч бүрээр нарийвчлан шалгаж дүгнэлт хийх боломжгүй болсон байна. Энэхүү зээлийг олгосноос хойш 13 жил болсон бөгөөд 2007 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас “Мал хамгаалах сан”-д “Праймланс” ББСБ-аас “ЭМААХДХ”-өөс олгосон зээлийн авлагаар 166.0 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Үүнээс үзэхэд 21.0 сая төгрөгийг хэдийд хаана төлсөн нь тодорхойгүй байгаа бөгөөд тухайн онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэж 77.7 сая төгрөгийг төлүүлж, 2018 оны 11 дүгээр сарын 12-ны байдлаар 88.2 сая төгрөгийн авлагатай байна.

Улсын төсвөөс олгож буй ноос, арьс ширний урамшууллын талаар.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоол /”Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журам”/, Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоол /”Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам шинэчлэн батлах тухай”/, мөн Засгийн газрын 394 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн малчдад мөнгөн урамшуулал олгох ажлыг тус тус зохион байгуулж хэрэгжүүлжээ.

№	Аймгийн нэр	Ноосны урамшуулал /сая төгрөгөөр/																			
		2011		2012		2013			2014			2015			2016			2017			
		Ноосны хэмжээ /кг/	Мөнгө н дүн	Малчны тоо	Ноосны хэмжээ /кг/	Мөнгөн дүн	Малчны тоо	Ноосны хэмжээ /кг/	Мөнгөн дүн	Малчны тоо	Ноосны хэмжээ /кг/	Мөнгөн дүн	Малчны тоо	Ноосны хэмжээ /кг/	Мөнгөн дүн	Малчны тоо	Ноосны хэмжээ /кг/	Мөнгөн дүн	Малчны тоо	Ноосны хэмжээ /кг/	Мөнгөн дүн
1	Архангай	338,679	677.4	9,879	1,320,977	2,642.0	11,199	1,747,868	3,495.7	10,256	1,956,466	1,822.8	8,297	1,641,523	1,728.4	10,241	2,094,104	2,209.1	9,663	2,145,627	2,287.5
2	Баян-Өлгий	21,245	42.5	4,416	345,736	691.5	6,495	540,106	1,080.2	3,184	336,233	335.3	3,166	416,136	416.2	5,262	613,379	614.0	4,771	552,997	554.5
3	Баянхонгор	202,306	404.6	6,578	687,451	1,374.9	8,130	915,669	1,831.3	3,399	733,215	592.7	3,412	676,776	825.3	4,825	855,985	1,020.7	3,398	715,401	920.5
4	Булган	459,861	919.7	5,520	1,035,831	2,071.7	6,060	1,264,617	2,529.2	4,516	1,146,556	1,146.4	3,634	959,705	960.8	5,264	1,364,914	1,365.9	4,681	1,208,729	1,209.1
5	Говь-Алтай	247,886	495.8	5,429	650,497	1,301.0	5,985	791,212	1,582.4	2,936	715,249	534.7	3,255	736,306	906.3	4,595	1,071,406	1,315.8	4,072	995,032	1,264.7
6	Говьсүмбэр	62,597	125.2	539	86,948	173.9	504	93,595	187.2	368	100,064	99.5	295	98,629	98.9	291	89,435	90.3	300	98,879	99.3
7	Дархан-Уул	16,858	33.7	507	102,774	205.5	570	118,075	236.1	455	115,881	115.9	286	78,547	78.5	416	110,731	110.7	398	96,417	96.4
8	Дорноговь	176,491	353.0	2,937	556,005	112.0	3,242	630,891	1,261.8	1,891	592,794	523.0	1,816	527,325	607.0	2,205	593,142	690.0	2,243	582,190	680.8
9	Дорнод	226,382	452.8	1,811	360,338	720.7	2,111	394,595	789.2	1,472	391,923	383.4	846	242,642	242.6	1,703	418,752	418.8	2,033	522,458	524.1
10	Дундговь	123,270	246.5	4,815	698,040	1,396.1	5,154	911,733	1,823.5	4,286	1,064,530	998.5	3,899	989,151	1,051.6	4,275	1,112,996	1,197.5	2,854	784,214	884.7
11	Завхан	612,640	1,225.3	7,734	1,050,392	2,100.8	8,237	1,323,293	2,646.6	6,176	1,415,218	1,264.1	6,663	1,480,236	1,668.9	7,388	1,667,343	1,872.1	5,843	1,496,510	1,686.7
12	Орхон	75,080	150.2	541	59,773	119.5	523	66,968	133.9	303	53,535	53.5	104	19,149	19.1	138	22,546	22.5	124	18,161	18.2
13	Өвөрхангай	108,098	216.2	9,193	1,019,943	2,039.9	11,126	1,358,860	2,717.7	9,667	1,481,952	1,456.1	8,705	1,474,057	1,537.3	9,359	1,689,848	1,752.7	9,810	1,992,219	2,071.4
14	Өмнөговь	14,421	28.8	3,270	556,409	1,112.8	4,067	699,621	1,399.2	2,282	930,380	565.8	2,286	583,072	922.0	2,950	744,509	1,166.8	2,856	757,171	1,254.3
15	Сүхбаатар	126,272	252.5	4,299	727,329	1,454.7	5,286	933,077	1,866.2	3,082	806,618	787.0	3,173	872,782	875.3	4,018	1,013,794	1,013.8	4,881	1,242,789	1,245.7
16	Сэлэнгэ	23,838	47.7	2,273	435,384	870.8	2,524	496,039	992.1	1,705	454,135	419.9	1,411	360,110	385.0	1,935	512,128	544.2	1,888	438,912	468.8
17	Төв	483,378	966.8	6,456	1,235,173	2,470.3	7,272	1,481,076	2,962.2	4,669	1,356,234	1,356.2	4,396	1,382,991	1,383.6	5,734	1,693,966	1,694.8	4,991	1,495,457	1,495.5
18	Увс	162,845	325.7	5,735	842,805	1,685.6	6,650	1,052,901	2,105.8	4,999	1,440,493	1,047.8	4,511	1,089,244	1,407.5	4,879	1,101,094	1,439.2	5,726	1,360,906	1,761.2
19	Улаанбаатар	13,123	26.2	319	47,776	95.6	465	75,080	150.2	289	66,666	66.7	230	57,088	57.1	258	64,226	64.2	180	48,275	48.3
20	Ховд	334,218	668.4	5,432	627,419	1,254.8	5,692	774,037	1,548.1	3,100	625,438	596.9	3,586	801,318	845.4	4,142	905,221	954.7	2,837	585,720	629.6
21	Хөвсгөл	679,343	1,358.7	11,224	1,335,591	2,671.2	11,776	1,535,073	3,070.1	8,444	1,533,673	1,403.3	7,750	1,493,971	1,681.1	9,390	1,800,206	2,020.0	9,113	1,793,933	2,037.7
22	Хэнтий	422,168	844.3	4,255	913,034	1,826.1	4,599	1,102,954	2,205.9	3,140	1,084,650	1,074.0	2,666	916,293	916.8	3,617	1,059,178	1,059.3	4,323	1,312,141	1,312.1
Нийт дүн		4,930,998	9,862.0	103,162	14,695,625	28,391.2	117,667	18,307,338	36,614.7	80,619	18,401,901	16,643.5	74,387	16,897,049	18,615.0	92,885	20,598,900	22,637.2	86,985	20,244,138	22,550.8

№	Аймгийн нэр	Арьс, ширний урамшуулал /сая төгрөгөөр/											
		2013 оны сүүлийн хагас жил				2014 оны эхний хагас жил				2014 оны сүүлийн хагас жил			
		Малчны тоо	Бодын тоо	Богын тоо	Нийт мөнгөн дүн	Малчны тоо	Бодын тоо	Богын тоо	Нийт мөнгөн дүн	Малчны тоо	Бодын тоо	Богын тоо	Нийт мөнгөн дүн
1	Архангай	1,424	3,950	29,008	146.3	128	205	2,306	10.0	6,453	28,901	178,694	969.6
2	Баян-Өлгий	467	276	6,763	24.4				0.0	834	411	13,537	46.8
3	Баянхонгор	5,712	1,324	94,587	303.6				0.0	1,804	3,007	63,494	235.6
4	Булган	816	1,374	10,619	52.5	319	439	3,852	18.1	2,434	7,962	54,402	282.6
5	Говь-Алтай	1,289	265	30,453	95.3	757	2	8,030	24.1	2,772	1,151	82,629	265.2
6	Говьсүмбэр	-	-	-	0.0				0.0	272	1,005	22,365	82.2
7	Дархан-Уул	372	3,263	23,772	120.3	80	293	4,410	17.6	534	5,354	38,962	197.2
8	Дорноговь	536	931	17,366	66.1	85	190	2,592	10.6	1,170	4,245	49,090	210.9
9	Дорнод	95	430	2,297	13.3	27	43	1,071	3.9	624	5,623	38,083	198.6
10	Дундговь	502	97	10,733	33.7				0.0	2,927	3,907	109,821	388.1
11	Завхан	2,728	2,657	47,402	182.1	41		172	0.5	5,054	6,404	122,643	464.0
12	Орхон	-	-	-	0.0	76	293	1,264	8.2	163	587	3,488	19.3
13	Өвөрхангай	4,363	3,352	94,961	335.2	291	581	3,770	20.0	8,617	14,571	240,001	938.6
14	Өмнөговь	1,144	469	21,625	71.9	38	19	469	1.7	1,874	1,786	57,527	199.4
15	Сүхбаатар	1,144	3,451	30,647	143.7	128	51	2,478	8.2	1,950	10,787	78,494	397.3
16	Сэлэнгэ	649	945	8,086	38.4	12	30	311	1.4	1,446	7,144	63,864	298.8
17	Төв	501	992	13,713	56.0	775	1,270	19,035	76.2	3,341	13,012	137,092	606.5
18	Увс	349	48	8,189	25.3				0.0	2,015	3,864	58,807	234.4
19	Улаанбаатар	-	-	-	0.0				0.0	185	1,168	7,375	39.6
20	Ховд	544	700	9,386	38.7	218	1	814	2.5	1,643	2,592	38,251	153.6
21	Хөвсгөл	5,962	10,296	214,995	799.4				0.0	6,494	20,944	219,807	973.6
22	Хэнтий	1,214	5,800	26,195	165.6	110	389	3,610	16.7	1,929	15,229	176,517	758.0
Нийт дүн		29,811	40,620	700,797	2,711.7	3,085	3,806	54,184	219.6	54,535	159,654	1,854,943	7,959.6

№	Аймгийн нэр	Арьс, ширний урамшуулал /сая төгрөгөөр/											
		2015 оны сүүлийн хагас жил				2016 оны сүүлийн хагас жил				2017 оны сүүлийн хагас жил			
		Малчны тоо	Бодын тоо	Богын тоо	Нийт мөнгөн дүн	Малчны тоо	Бодын тоо	Богын тоо	Нийт мөнгөн дүн	Малчны тоо	Бодын тоо	Богын тоо	Нийт мөнгөн дүн
1	Архангай	4,523	25,036	172,135	891.9	5,879	43,374	187,446	1,212.9	8,978	62,139	244,571	1,665.8
2	Баян-Өлгий	992	1,148	22,580	85.0	1,440	1,500	29,504	111.0	1,900	2,629	39,918	159.2
3	Баянхонгор	1,087	3,713	41,365	179.8	2,411	4,824	89,020	339.4	3,681	9,133	130,877	529.6

4	Булган	1,536	6,405	52,737	254.3	3,044	12,455	96,299	475.7	3,496	23,748	103,350	666.3
5	Говь-Алтай	1,785	827	74,473	235.8	2,832	1,465	109,117	349.3	9,791	31,271	369,581	1,577.8
6	Говьсүмбэр	270	923	31,139	107.3	382	2,984	48,037	188.9	3,896	2,896	182,752	591.7
7	Дархан-Уул	467	5,527	43,486	213.4	595	7,162	39,086	224.7	409	2,327	40,324	155.9
8	Дорноговь	911	3,794	67,532	259.5	1,052	4,083	47,856	204.8	683	7,530	32,159	209.4
9	Дорнод	447	7,135	43,770	238.3	959	14,455	67,731	420.0	1,583	5,546	66,855	283.8
10	Дундговь	3,055	2,034	187,918	594.3	4,049	3,599	272,166	870.5	993	13,488	57,432	374.6
11	Завхан	2,128	2,023	70,774	242.7	3,775	7,931	107,144	440.4	4,158	5,323	257,748	853.1
12	Орхон	-	-	-	0.0	103	828	3,964	24.3	3,793	8,494	106,429	446.7
13	Өвөрхангай	6,486	10,465	251,102	910.3	8,537	18,530	335,105	1,283.3	2,436	1,256	100,700	320.9
14	Өмнөговь	1,264	1,302	42,092	145.8	1,891	1,214	69,924	228.0	210	2,275	5,943	52.0
15	Сүхбаатар	1,321	10,246	71,855	369.3	2,241	19,911	140,578	720.4	3,231	26,721	158,377	875.9
16	Сэлэнгэ	1,372	12,842	98,125	487.0	1,715	15,517	102,152	539.2	1,976	16,004	87,273	501.9
17	Төв	3,590	21,539	246,557	1,062.8	4,675	30,571	258,402	1,233.8	5,167	38,191	259,807	1,352.3
18	Увс	2,466	6,364	143,307	525.4	3,705	4,051	143,688	491.8	5,050	10,044	173,482	671.1
19	Улаанбаатар	2,959	26,821	296,850	1,292.9	224	1,766	13,333	66.5	247	1,623	5,226	40.0
20	Ховд	132	22	11,107	33.7	3,437	7,626	126,062	492.6	8,409	28,290	240,906	1,147.1
21	Хөвсгөл	2,023	1,760	75,024	251.5	7,683	32,125	304,282	1,394.7	3,648	8,297	131,733	519.7
22	Хэнтий	5,987	22,385	306,050	1,253.9	3,626	42,214	255,851	1,400.8	4,260	43,547	321,189	1,616.8
Нийт дүн		44,801	172,311	2,349,978	9,634.6	64,255	278,185	2,846,747	12,713.0	77,995	350,772	3,116,632	14,611.5

Мал хамгаалах сангаар дамжуулан улсын төсвөөс жил бүр 22 аймгийн малчдаас бэлтгэн үндэсний үйлдвэрүүдэд тушаасан ноосны урамшууллыг холбогдох анхан шатны баримтыг үндэслэн дараах байдлаар олгосон байна.

Үүнд: 2011 онд 22 аймгийн 4,930,998 кг ноосонд 9,862.0 сая төгрөгийг, 2012 онд 14,695,625 кг ноосонд 103,162 малчин, мал бүхий иргэнд 28,391.2 сая төгрөгийг, 2013 онд 18,307,338 кг ноосонд 117,667 малчин, мал бүхий иргэнд 36,614.7 сая төгрөгийг, 2014 онд 18,401,901 кг ноосонд 80,619 малчин, мал бүхий иргэнд 16,643.5 сая төгрөгийг, 2015 онд 16,897,049 кг ноосонд 74,387 малчин, мал бүхий иргэнд 18,615.0 сая төгрөгийг, 2016 онд 20,598,900 кг ноосонд 92,885 малчин, мал бүхий иргэнд 22,637.2 сая төгрөгийг, 2017 онд 20,244,138 кг ноосонд 86,985 малчин, мал бүхий иргэнд 22,550.8 сая төгрөгийг тус тус олгожээ

Сүүлийн 7 жилд улсын хэмжээгээр 22 аймгийн малчид, мал бүхий иргэдээс, үндэсний үйлдвэрүүдэд тушаасан нийт 114,075,949 кг ноосны урамшуулалд 155,314.4 сая төгрөгийг улсын төсвөөс олгож, малчид мал бүхий иргэдэд дэмжлэг үзүүлжээ.

Мөн сүүлийн /2013-2017 онуудад/ 5 жилд арьс ширний урамшуулалд 47,850.0 сая төгрөгийг олгож дэмжлэг үзүүлсэн байна. Дээрхи хугацаанд бодын шир 1,005,348 ширхэг,

богийн арьс, нэхий 10,923,281 ширхэг, нийтдээ 11,928,629 ширхэг хонь ямааны нэхий, арьс үхэр адууны шир үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлэгджээ.

Харин 2018 оны ноосны урамшууллын 22,500.0 сая төгрөгийн урамшуулал олгогдсон, арьс ширний урамшууллын 13,100.0 сая төгрөгийн урамшууллын эрх нээгдээгүй тул олгогдоогүй хүлээгдэж байна.

Малын тэжээлийн хангамжийг сайжруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр аж ахуйн нэгжүүдэд хүүгүй олгосон зээлийн талаар.

Малын тэжээлийн хангамжийг сайжруулах зорилгоор 2017 оны төсвийн тодотголд 40.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг нь тусган өвс тэжээл импортлох болон дотооддоо үйлдвэрлэн малчид, фермерүүдэд нийлүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүд, тэдгээрт олгох санхүүжилтийн дээд хязгаарыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/149 тоот тогтоолоор 29 аж ахуйн нэгжид 40,0 тэрбум төгрөгийн зээлийг 9 сарын хугацаатайгаар хүүгүй олгох шийдвэрийг гаргасан байна.

Мөн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/161 тоот тушаалаар өмнө гаргасан тушаалаар өвс тэжээл импортлох болон дотооддоо үйлдвэрлэн малчид фермерүүдэд нийлүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүдээс барьцаа хөрөнгийн үнэлгээнээс шалтгаалан 10 аж ахуйн нэгжтэй зээлийн хэмжээг бууруулж гэрээ байгуулсан, 1 аж ахуйн нэгжтэй барьцаа хөрөнгө нь шаардлага хангаагүйгээс гэрээ байгуулаагүй тул 3,720.0 сая төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/161 тоот тушаалаар “Эрдэнэт фүүдс” ХХК-тай 1,000.0 сая төгрөгийн, “Майнд тэч” ХХК-тай 800.0 сая төгрөгийн, “Өег гурил” ХХК-тай 700.0 сая төгрөгийн, “Арвижих Увс” ХХК-тай 500.0 сая төгрөгийн, “Орос ах” ХХК-тай 400.0 сая төгрөгийн, “Алтайн сүрлэг нуруу” ХХК-тай 320.0 сая төгрөгийн гэрээ байгуулахыг Мал хамгаалах санд зөвшөөрсөн байна.

Тус хөрөнгөөр малын тэжээл импортлон оруулж ирэхээр Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төсөл сонгон шалгаруулалт зарлаж, өвс, тэжээл импортлон борлуулах ажлыг улсын хэмжээнд нийт 34 аж ахуй нэгж гүйцэтгэж импортлох болсон байна.

Мал хамгаалах сангаар дамжуулан тус хөрөнгийг зээлийн гэрээ байгуулан авсан бөгөөд 2018 оны оны 08 дугаар сарын 01-ны өдөр гэхэд буцааж төлөх үүрэгтэй. Өвс, тэжээл нийлүүлэх аж ахуйн нэгжүүдтэй хийгдсэн гэрээний дагуу 2017 оны жилийн эцсийн байдлаар 21,186.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 2018 онд 18,813.6 сая төгрөгийг санхүүжүүлжээ.

Тушаалын гарав дах заалтад барьцаа хөрөнгийн шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй бодлогын гэрээний нөхцлийн дагуу 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл зээлийн гэрээ байгуулж, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сангийн захиралд даалгажээ.

Дотооддоо үйлдвэрлэсэн болон ОХУ-аас малын тэжээл импортлоход зээл авсан аж ахуйн нэгжүүдийн зээлийн эргэн төлөлтийн байдал.

/төгрөгөөр/

№	Аймаг	ААН-ийн нэрс	Олгосон зээл	Зээлдэгчийн нэр	Нийт эргэн төлөлт	Үлдэгдэл
1	Улаанбаатар	Биохэлф монголиа ХХК	900,000,000	Г.Ганбаяр	-	900,000,000
2	Улаанбаатар	Туртелком ХХК	1,000,000,000	С.Мөнхжаргал	-	1,000,000,000
3	Улаанбаатар	Галин интернешнл ХХК	1,100,000,000	М.Энхбаяр	-	1,100,000,000
4	Улаанбаатар	Бадрангуй Орших ХХК	660,000,000	Н.Батхишиг	33,250,000	626,750,000
5	Улаанбаатар	Эрхжин ХХК	650,000,000	Ж.Саруул	34,502,000	615,498,000
6	Улаанбаатар	Арованно ХХК	5,000,000,000	Д.Ганзориг	297,400,000	4,702,600,000
7	Улаанбаатар	Майндтэч ХХК	800,000,000	У.Мөнхжаргал	50,000,000	750,000,000
8	Завхан	Нисэг Агро ХХК	250,000,000	О.Эрдэнэчимэг	29,966,800	220,033,200
9	Улаанбаатар	Хийморлог эрчүүдийн хүч	800,000,000	Х.Бат-Амгалан	130,000,000	670,000,000
10	Дархан	Батдэлгэр трейд ХХК	400,000,000	Г.Буяндэлгэр	75,000,000	325,000,000
11	Хөвсгөл	Хөвсгөл Алтан дуулга ХХК	5,000,000,000	Д.Дуламсүрэн	1,157,000,000	3,843,000,000
12	Улаанбаатар	Чансаа хан хөхий холдинг ХХК	3,000,000,000	Н.Болорчулуун	710,000,000	2,290,000,000
13	Говь-алтай	Алтайн сүрлэг нуруу ХХК	320,000,000	Н.Батболд	79,000,000	241,000,000
14	Улаанбаатар	ЧМТО ХХК	2,000,000,000	Ж.Чинзориг	500,000,000	1,500,000,000
15	Улаанбаатар	Йиствест ресурс	1,100,000,000	Т. Мөнхтуяа	291,402,320	808,597,680
16	Улаанбаатар	Пепмайд ХХК	300,000,000	Б.Чингэс	96,795,000	203,205,000

17	Өвөрхангай	Бор банди ХХК	190,000,000	Р.Баатарсүрэн	72,469,800	117,530,200
18	Улаанбаатар	Жи Өү Ти Ти ХХК	2,000,000,000	Н.Оюунчимэг	805,000,000	1,195,000,000
19	Увс	Арвижих увс ХХК	500,000,000	Х.Сүхбаатар	250,000,000	250,000,000
20	Улаанбаатар	Орос ах ХХК	400,000,000	Д.Жаргалсүрэн	217,444,200	182,555,800
21	Улаанбаатар	Дөлгөөн-Оргил ХХК	800,000,000	Д.Тэрбиш	680,000,000	120,000,000
23	Ховд	Жинст транс ХХК	1,300,000,000	И.Идэрбат	1,219,482,000	80,518,000
22	Завхан	Эйч Эс Эм ХХК	1,000,000,000	З.Хүрэлбаатар	1,000,000,000	-
24	Улаанбаатар	Од групп ХХК	2,000,000,000	П.Бат-Оргил	2,000,000,000	-
25	Орхон	Эрдэнэт фүүдс ХХК	1,000,000,000	Ш.Алтанхуяг	1,000,000,000	-
26	Дархан	Өег гурил ХХК	700,000,000	А.Батсуурь	700,000,000	-
27	Дархан	Энсада Тракторан ХХК	730,000,000	Д.Батдорж	730,000,000	-
28	Увс	Аянжин ХХК	450,000,000	Ц.Очирбат	450,000,000	-
29	Улаанбаатар	Архалиун цамхаг ХХК	750,000,000	Д.Ариунбаяр	750,000,000	-
30	Улаанбаатар	Түмэн шувуут ХХК	1,000,000,000	Ж.Болд	1,000,000,000	-
31	Увс	Хархираан хөгжил ХХК	600,000,000	Л.Мөнхнаран	600,000,000	-
32	Улаанбаатар	Милл Хаус ХХК	2,000,000,000	Ж.Чинзориг	2,000,000,000	-
33	Баян-өлгий	Асгат кент ХХК	800,000,000	Х.Муратай	800,000,000	-
34	Улаанбаатар	Ондилт ХХК	500,000,000	Т.Чинзориг	500,000,000	-
Нийт			40,000,000,000	-	18,258,712,120	21,741,287,880

Улсын төсвийн хөрөнгөөр малын тэжээл бэлтгэн, борлуулах ажлыг гүйцэтгүүлэх гүйцэтгэгч компаниудын сонгон шалгаруулалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зохион байгуулсан бөгөөд шалгалтын Ажлын хэсэг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж дүгнэлт хийх боломжгүй байлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүргийг хэрэгжүүлдэг тусгай агентлаг байсаар байтал тус агентлагаар гүйцэтгүүлээгүй байна.

Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/161 тоот тушаалаар Өвс, тэжээл импортлох болон дотооддоо үйлдвэрлэн, борлуулах сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүдээс барьцаа хөрөнгийн үнэлгээнээс шалтгаалан 10 аж ахуйн нэгжтэй, олгох зээлийн хэмжээг бууруулж гэрээ байгуулсан, 1 аж ахуйн нэгжтэй /Мөрөн агро ХХК, 160.0 сая төгрөг/ барьцаа хөрөнгийн үнэлгээ шаардлага хангаагүй зэргээс шалтгаалж, гэрээ байгуулаагүй тул 3,720.0 сая төгрөгийн зээлийг Эрдэнэт фүүдс ХХК-д 1,0 тэрбум төгрөг, Майнд тэч ХХК-д 800.0 сая төгрөг, Өег гурил ХХК-д 700.0 сая төгрөг, Арвижих Увс ХХК-д 500.0 сая төгрөг, Орос ах ХХК-д 400.0 сая төгрөг, Алтайн сүрлэг нуруу ХХК-д 320.0 сая төгрөгийг тус тус хуваарилсан тушаалыг нэмж гаргасан байна.

Эдгээр компаниудыг хэрхэн яаж сонгон шалгаруулж, зээлийн эх үүсвэрийг хуваарилсан нь тодорхойгүй, зөвхөн сайдын тушаалд зээл олгох аж ахуйн нэгжүүдийн нэр, олгох зээлийн хэмжээг тогтоон Мал хамгаалах санд гэрээ байгуулсан олго гэсэн шийдвэрийг үндэслэн зээл олгожээ. Эдгээр компаниудын малын тэжээл бэлтгэн борлуулсан тухай тайлан мэдээ, гэрээ дүгнэсэн акт, нэгтгэсэн материал байхгүй байна.

Энэхүү зээлийн гэрээнд зааснаар эргэн төлөлт хийх хугацаа энэ оны 8 дугаар сарын 01-ний өдрөөр дууссан байна.

Малын тэжээл бэлтгэн нийлүүлэх зээлд хамрагдсан 27 компани нь 300,000-1,000,000 төгрөгийн зээл авсан байхад, харин “Арованно” ХХК, “Хөвсгөл Алтан дуулга” ХХК-иуд тус бүр 5,000,000 төгрөгийн, “Чансаа Хан Хөхий” холдинг ХХК 3,000,000 төгрөгийн, “ЧМТО” ХХК 2,000,000 төгрөгийн, “Жи Өү Ти Ти” ХХК 2,000,000 төгрөгийн, “Од групп” ХХК 2,000,000 төгрөгийн, “Жинст транс” ХХК 1,300,000 төгрөгийн, “Милл хаус” ХХК 2,000.0 сая төгрөгийн хүүгүй зээлийг тус тус авсан баримт байна.

Зээлийн эргэн төлөлтийг 2018 оны 11 дүгээр сарын байдлаар авч үзэхэд 40.0 тэрбум төгрөгийн зээл авсан 34 компаниас 31 компани нь 18,258,712.1 мянган төгрөгийн зээлийг эргэн төлсөн бөгөөд одоо 23 компаниас 22,886,367.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд Мал хамгаалах сангаас гэрээнд зааснаар гүйцэтгээгүй /төлөлт хийгээгүй зээлийн үлдэгдэл/ үнийн дүнгээс алданги тооцож, зээлдэгчийн харъяалах шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байна.

Энэ оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар зээлийн эргэн төлөлт 45.6 хувьтай байгаа бөгөөд зээлийг эргэн төлүүлэх талаар сангийн ажилтнууд төлөвлөгөө гарган хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж байна.

Гэрээ ёсоор зээлийг төлж дуусах хугацаа 3 сар гаруйгаар өнгөрч, авсан зээлээ төлөхгүй байгаа зээлдэгч нараас гэрээнд заасан ёсоор, алданги тооцон шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байгаа бөгөөд зарим зээлдэгчийн шүүх хурал болж шийдвэр нь гарсан, зарим зээлдэгчийн шүүх хурлын тов зарлагдсан байдалтай байна.

Нийт 34 зээлдэгчээс одоогийн байдлаар 10,830.0 сая төгрөгийн зээл авсан 12 компани зээлээ бүрэн төлж барагдуулсан, харин “Биохэлф монголиа” ХХК 900.0 сая төгрөгийн, “Туртелком” ХХК 1.0 тэрбум төгрөгийн, “Галин интернейшнл” ХХК 1.1 тэрбум төгрөгийн зээлийг авсан боловч өнөөг болтол огт төлж эхлээгүй байна.

“Гацуурт” ХХК-иас “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн дэмжих хөтөлбөр” хэрэгжүүлсэн талаар.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Махны цэвэр үүлдэрийн үхрийг импортолж үржлийн аж ахуй эрхлэх” төсөл сонгон шалгаруулах тендерийг 2011 он зарлан сонгон шалгаруулалтад шалгарсан “Гацуурт” ХХК-д төслийн дэмжлэгт зориулан 1.0 тэрбум төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/102 тоот тушаал гарч дээрхи хөтөлбөрийн 2011 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж, Мал хамгаалах сангаар дамжуулан олгожээ.

“Гацуурт” ХХК –тай махны чиглэлийн цэвэр үүлдэрийн үхэр импортолж, үржлийн цогцолбор аж ахуй эрхлэх, хамтран ажиллах гэрээг байгуулах, олгосон санхүүжилтийг 6 жилд багтаан стандартын шаардлага хангасан үржлийн өсвөр хээлтэгч үхрээр Мал хамгаалах санд төвлөрүүлэх арга хэмжээ авахыг тус сангийн захиралд даалгасан байна. Зээлийн “ЭМААХДХ”-2011/07 тоот гэрээний 3.1.1-д 1.0 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөх хуваарийн дагуу 6 жилийн дараа 200 толгой өсвөр хээлтэгч, хээлтүүлэгчээр эргүүлэн төлнө.

Гэрээний 3.2-д Зээлдэгч оруулж ирсэн үхрийг дараах эргэн төлөх хуваарийн дагуу зээлдүүлэгчид төлнө. Зээлдүүлэгчид 18-22 сараас доошгүй настай, махны чиглэлийн тухайн үүлдэрийн стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч, хээлтэгчийг 50 хувийн харьцаатайгаар хүлээлгэн өгнө гэж заажээ.

Гэрээг 2011 оны 7 дугаар сарын 09-ны өдөр байгуулсан, Үржлийн үхрийг бойжуулж өсгөх, үржүүлэх хугацаа: 2011.07-2015.07 сар, зээл төлөх эхний хугацаа: 2015.07.15-нд 30 хувь буюу 60 толгой хээлтэгч, хээлтүүлэгч, зээл төлөх дунд хугацаа: 2016.07.15-нд 60 толгой хээлтэгч, хээлтүүлэгч, зээл төлөх эцсийн хугацаа 2017.07.15-нд 40 хувь буюу 80 толгой хээлтэгч, хээлтүүлэгчийг хүлээн авна.

Гэрээний 3.3-д Зээлдүүлэгч болон түүний томилсон албан ёсны төлөөлөгч нь энэ гэрээний 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг заасан хугацаанд зээлдэгчийн эргүүлэн төлөх үхрийг акт үйлдэн Сэлэнгэ аймгийн Цагааннуур суман дахь аж ахуйгаас хүлээн авна. 3.4-д Зээлдэгч зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу хийж чадахгүй болсон тохиолдолд 1 толгой үхрийг мөнгөн дүнд шилжүүлсэн дүнгээр төлбөрийг барагдуулах болно гэжээ.

Үүнээс хойш Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 22-ны А/249 тоот тушаалаар ажлын хэсэг томилж ЭМААХДХ-2011/07 дугаартай төслийн зээлийн гэрээний дагуу “Лимузин” үүлдэрийн стандартын шаардлага хангасан 18-22 сартай 60 толгой хээлтүүлэгчийг шалган хүлээн авах үүрэг бүхий ажлыгн хэсгийг байгуулж, 2015 онд хүлээн авах махны чиглэлийн Лимузин үүлдэрийн цэвэр цусны 30 толгой хээлтэгч, 30 толгой хээлтүүлэгчийг холбогдох стандарт, гэрээний нөхцөл,

шаардлагад нийцүүлэн авч, үхэр нэг бүрт тэмдэг, тэмдэглэгээ хийж ялган суурилах зэрэг ажлыг гүйцэтгэн ажлын дүнг 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч П.Ганхуягт даалгажээ.

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй тул зээлдүүлэгч удаа дараа хөөцөлдөж, улмаар Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Мал хамгаалах сан нэхэмжлэл гаргасан боловч 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдөр тус дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 102/ШШ2016/04380 тоот шийдвэр гарч нэхэмжлэлийг хэргсэхгүй болгожээ.

“Гацуурт” ХХК нь мөн 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжргалтай гэрээ байгуулан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Франц улсаас импортоор авсан махны чиглэлийн цэвэр үүлдэрийн үхрийг “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд үржүүлж, хамтран ажиллах гэрээг байгуулан 2.0 тэрбум төгрөгийн зээлийг авчээ. Гэрээний 2 дахь хэсгийн 2.2-д 1.0 тэрбум төгрөгийг 2012 онд хэрэгжүүлэгчид олгосон тул, үлдэгдэл санхүүжилт 1.0 тэрбум төгрөгийг зээлдэгчийн дансанд шилжүүлэхээр заажээ.

Гэрээний 2.3-д УИХ-ын 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Төсвийн тухай хууль”-ийн 4.1.24 дэхь заалт “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн хөрөнгийн зарлагыг”-ын дагуу тус бүр нь 11,363,636 /арван нэгэн сая, гурван зуун жаран гурван мянга, зургаан зуун гучин зургаа/ төгрөгийн, /нийт 2,0 тэрбум төгрөгийн/ үнэ бүхий /1 настай мах, сүүний чиглэлийн Монтбелард цэвэр үүлдэрийн эр 2 толгой/, эм 30 толгой, махны чиглэлийн Лимузин цэвэр үүлдрийн эр 6 толгой, эм 138 толгой/ нийт 176 толгой үхрийг ҮХААЯ-ны харъяа Мал хамгаалах сангийн хөрөнгийн бүртгэлд тусгана.

Гэрээний 2.5-д “Гацуурт” ХХК-нь энэхүү гэрээний 2.3-д заасан 176 толгой цэвэр үүлдрийн үхрийг стандартын шаардлагад нийцүүлэн доорхи хуваарийн дагуу хөрөнгө оруулагч талд өгнө. Үүнд: Үржлийн үхэр бойжуулж, үржүүлэх хугацаа: 2012-2019 он, гэрээ байгуулсан хугацаа: 2013.12.16, хөрөнгө оруулалтыг нөхөх, 2017.07 сар, 30 хувийг төлөх 52 толгой хээлтэгч, хээлтүүлэгч, хөрөнгө оруулалтыг нөхөх, 2018.07 сар 30 хувийг хүлээлгэн өгөх 52 толгой хээлтэгч, хээлтүүлэгч, хөрөнгө оруулалтыг нөхөх 2019.07 сард 40 хувь 72 толгой хээлтэгч, хээлтүүлэгч өгөхөөр гэрээнд тусгажээ.

Үүнээс хойш 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 1/670 тоот албан бичгээр Мал хамгаалах сангийн захиралд хандаж ирүүлсэн дүгнэлтдээ: “Гацуурт” ХХК-ийн ерөнхий захирал Л.Чинбат нь “Гацуурт” ХХК 2003 оноос хойш Канад улсаас мах, сүүний чиглэлийн “Ангус” үүлдэрийн үхрийн үр хөврөл оруулж ирж үржүүлэн, эрчимжсэн мал аж ахуйг буй болгож, орон нутагт тогтмол орлогын эх үүсвэртэй болгох зорилго тавин ажиллаж байна. Мөн 2011 оноос “Ангус”, “Лимузин”, “Мон билард”, “Холштейн” үүлдэрийн үхрүүдийг Франц улсаас оруулан ирж үржүүлж байна. Эдгээр 4 үүлдрийн үхрүүд нь өөр өөрийн онцлог давуу сул талуудыг тус бүрд нь тайлбарлан Монгол улсад “Ангус” үүлдэрийн үхрийн үржлийн ажлыг тасралтгүй хангах боломж манай компанид бүрдсэн тул төслийн хүрээнд хүлээлгэж өгөх үхрээ ихэнхдээ малчдад очих учраас “Ангус” үүлдэрийн үхэр тараах нь оновчтой гэсэн санал ирүүлжээ.

ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/90, А/131 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг төслийн ажлын явц байдал, гэрээний үүргийн хэргжилттэй танилцах ажлын хэсгийг 2 удаа томилж ажиллуулсан байна. Ажлын хэсэг 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Зэлтэр зэрэг суманд ажиллаж, илтгэх хуудас бичиж яаманд танилцуулсан байна.

Энэ байдлаас үзэхэд: ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Мал хамгаалах сан, “Гацуурт” ХХК-тай байгуулсан “ЭМААХДХ”-2011/07 тоот гэрээгээ дүгнэж, акт үйлдээгүй нь 2015, 2016 онуудад гэрээний хэрэгжилт хангагдаагүй, зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

ХХААХҮ-ийн сайдын 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/102 дугаар тушаалыг үндэслэн махны цэвэр үүлдрийн үхэр импортолж, үржлийн аж ахуй эрхлэх төслийг хэрэгжүүлэхэд зээлийн гэрээгээр зээлдэгч 1.0 тэрбум төгрөгийг тодорхой нас хүйсний өсвөр насны хээлтэгч, хээлтүүлэгчээр 6 жилийн хугацаанд 200 толгой үхрээр төлнө гэсэн нь нэг үхрийн өртөг 5.0 сая орчим төгрөгөөр өгөх саналтай байсан байна.

Зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүйгээс үүссэн алданги нь 2017 онд 21.9 сая төгрөг, 2016 онд 11.0 сая төгрөг орчим нийт 32.9 сая төгрөг байхаар үүнийг үхэрт шилжүүлэн тооцвол 6 үхрийг нэмж авахаар байсан боловч алдангийг тооцоогүй байжээ.

ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Үнэ тогтоох, хуваарь батлах тухай А/135 тоот тушаалаар “Гацуурт” ХХК-иас зээлийн эргэн төлбөрт 200 толгой “Ангус” үүлдэрийн хээлтэгч, хээлтүүлэгч үхрийг нэг бүрийг 5.0 сая төгрөгөөр үнэлэн хүлээн авч, үүссэн алдангийг чөлөөлсөн шийдвэр гаргажээ.

Мөн анхны гэрээг зөрчиж цэвэр цусны “Лимузин” үүлдрийн үхэр аваагүй, “Ангус” үүлдрийн үхэр болж өөрчлөгдсөн энэ тохиолдолд үнэлгээний зөрүү гарах ёстой үүнийг харгалзалгүйгээр 1.0 тэрбум төгрөгийн зээлийг хааж, 2.0 тэрбум төгрөгийн зээлийн авлагатай байна.

Мөн 2013 онд байгуулсан гэрээ ёсоор 2017 оны 7 дугаар сард 52 толгой, 2018 оны 7 сард мөн 52 толгой, нийт 104 толгой цэвэр цусны хээлтэгч, хээлтүүлэгчийг хүлээлгэн өгсөн байх, гэрээний үүргийг зөрчсөн байна.

“Сүүний чиглэлийн ямааны аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр хэрэгжүүлсэн “АТААСҮ” ХХК-ийн талаар.

Өвөрхангай аймаг дахь “АТААСҮ” ХХК-ны “Сүүний чиглэлийн ямааны аж ахуйг хөгжүүлэх” 2013/01 дугаартай зээлийн гэрээгээр 450.0 сая төгрөгийн өртөг бүхий сүүний чиглэлийн “Альпин” үүлдрийн 200 толгой хээлтэгч, хээлтүүлэгчийг Франц улсаас импортлон, 5 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж, 2015 онд 90 хээлтүүлэгч, 70 хээлтэгч, 2016 онд 54 хээлтүүлэгч, 106 хээлтэгч, 2017 онд 20 хээлтүүлэгч, 194 хээлтэгч, нийт 164 хээлтүүлэгч, 370 хээлтэгч буюу “Альпин” үүлдрийн ямааг зээлийн төлбөрт хүлээлгэн өгөхөөр төсөл хэрэгжүүлж байна. Тус компанийн зүгээс зээлийн төлбөрт үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч хүлээлгэн өгөхөөр /хээлтүүлэгч 20, хээлтэгч/ 40-50 толгойг өгөхийн зэрэгцээ “үр хөврөл” нийлүүлж гэрээг дүгнэх ажлыг хийх саналыг удаа дараа тавьж байгаа боловч ХХААХҮЯ, МХСангаас тодорхой хариу өгдөггүй гэсэн байна. Дүгнэхэд: ҮХААЯ-ны Мал аж

ахуйн газар нь “АТААСҮ” ХХК-тай 2013 оны 6 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан 2013/01 дугаартай гэрээг байгуулж, Мал хамгаалах сан нь дээрхи компанитай Барьцааны гэрээ байгуулахдаа “2013/01 тоот барьцааны гэрээ”-г барьцаалсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Зээлийн гэрээг талууд 2015, 2016, 2017 онд дүгнээгүй байгаа нь маргаан дагуулсан, зээлдүүлэгч тал нь зээлийн гэрээний 3.3, 3.4, 3.5, 3.7 дахь, зээлдэгч тал нь зээлийн гэрээний 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.6 дахь заалтуудыг хэргжүүлээгүй, талууд зээл төлөх хуваарийн 2.2, 2.3, 2.4, 2.5 дахь заалтуудыг мөрдөж ажиллаагүй зэрэг нь зээлийн гэрээний 5-д заасан хариуцлагыг хүлээлгэхэд хүндрэлтэй болжээ.

Мал хамгаалах сангаас 2012-2018 онуудад ААНБ болон малчид, мал бүхий иргэд, аймгуудын ХААГ-т бэлтгэн нийлүүлсэн техник тоног төхөөрөмжийн талаар

Тус санд 2012-2018 онуудад ХХААХҮ-ийн сайдын багцаар дамжуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 төрлийн 9,509.2 сая төгрөгийн үнэ бүхий техник, тоног төхөөрөмж бэлтгэгджээ. Үүнээс: 2012 онд 6 төрлийн 223 ширхэг 573.8 сая төгрөгийн, 2013 онд 4 төрлийн 210 ширхэг 1,920.4 сая төгрөгийн, 2014 онд 8 төрлийн 142 ширхэг 2,120.7 сая төгрөгийн, 2015 онд 8 төрлийн 32 ширхэг 963.1 сая төгрөгийн, 2016 онд 4 төрлийн 22 ширхэг 2,629.3 сая төгрөгийн, 2017 онд 3 төрлийн 8 ширхэг 142.7 сая төгрөгийн, 2018 онд 3 төрлийн 28 төрлийн 120.7 сая төгрөгийн малын тэжээлийн үйлдвэрийн иж бүрдэл, ногоон тэжээлийн үйлдвэр, өвс хаман боогч, хадлангийн иж бүрдэл, хөдөлгөөнт гар хадуур, худгийн өрөмдлөгийн машин /иж бүрдэл/, хүчит тэжээлийн үйлдвэр, цахилгаан саалтуур, сүүний хөргөлтийн танк /ОХУ/, Малын тэжээлийн үйлдвэрийн иж бүрдэл зэрэг нийт 13 төрлийн 665 ширхэг 8,508.2 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг ААНБ, малчид, мал бүхий иргэд, аймгуудад нийлүүлсэн байна.

Худалдан борлуулсан техник, тоног төхөөрөмж, түүний орлогын талаар

Мал хамгаалах сангаас 2012-2018 онуудад нийтдээ 562 ширхэг 6,129.1 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг худалдан борлуулсан бөгөөд борлуулалтын орлогоор 5,061.6 сая төгрөгийг оруулж, 1,067.5 сая төгрөгийг дутуу төлөлтэй байна. /хүснэгт оруулах/

Түрээслүүлсэн техник, тоног төхөөрөмжийн орлогын талаар

Түрээсээр 2013-2018 онуудад 8 төрлийн 107 ширхэг 4,430.2 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг 7 жилийн хугацаатай түрээсээр олгосон бөгөөд урьдчилгаа төлбөргүйгээр жилд 1,200.0-5,000.0 төгрөгийн түрээсийн зардал төлөхөөр олгосон нь дээрхи хугацаанд түрээсийн төлбөрөөр, анхны үнийнхээ 42.2-46.9 хувийг бүрдүүлээд 7 жил ашигласны дараа, дараагийн хэрэглэгчид хүлээлгэн өгөх боломжгүй болохоор байна. Цаашид 7 жил ашигласан, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дээрхи нөхцөлөөр хэнч авахгүй болох нь тодорхой байна.

Иймд түрээсийн бодлогыг нь бодит байдалд нийцүүлж, оновчтой болгох, өнөөгийн байдлаас үзэхэд өртгөө нөхөхөөргүй алдагдалтай байна. Түрээслүүлсэн хөрөнгийн үзэхэд түрээсийн түрээсээр 2014 оноос эхлэн 5 төрлийн 61 ширхэг техник тоног төхөөрөмжийг түрээслүүлж 73.2 сая төгрөгийн орлого оруулахаас нэг ч төгрөгийн орлого ороогүй, 2015

онд 5 төрлийн 69 шрхэг техник, тоног төхөөрөмжийг түрээслэн 169.3 сая төгрөгийн орлого оруулахаас 83.5 сая төгрөгийн орлого оруулж, 49.3 хувийн гүйцэтгэлтэй, 85.8 сая төгрөг дутуу, 2016 онд 5 нэрийн 75 ширхэг хөрөнгө түрээслэн, 192.3 сая төгрөгийн орлого оруулахаас 67.5 сая төгрөгийн орлого орж, 124.8 сая төгрөг дутуу, 35.1 хувийн гүйцэтгэлтэй, 2017 онд 5 нэрийн 77 ширхэг хөрөнгө түрээслэн, 198.8 сая төгрөгийн орлого оруулахаас 40.1 сая төгрөгийн орлого оруулж, 158.7 сая төгрөг дутуу 20.2 хувийн гүйцэтгэлтэй, 2018 онд 7 нэрийн 100 ширхэг хөрөнгө түрээслэн 227.6 сая төгрөгийн хөрөнгө түрээслэн, 227.3 сая төгрөгийн орлого оруулахаас 66.8 сая төгрөгийн орлого орж, 160.5 сая төгрөгөөр тасарч, 29.4 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Энэ байдлаас үзэхэд техник, тоног төхөөрөмжийн түрээсийн орлого жил бүр тасарч, орлогынхоо дөнгөж 20.2-29.4 хувийг бүрдүүлж, хөрөнгө нь жил бүр хуучирч, муудаж байгаагаас үзэхэд энэ талаар өөр бодлого баримтлах шаардлагатай болжээ. Харин эхний ээлжинд тодорхой хувийг төлөөд 4-5 жилд хүүгүй лизингийн хэлбэрээр ашиглан, лизингээ төлж дуусмагц өөрт нь үлдэхээр ашиглуулах гэрээ байгуулж ажиллах нь зүйтэй байна.

Мал амьтдын бүртгэл, зээлийн эргэн төлөлтийн талаар:

Мал хамгаалах сангийн 2017 оны санхүүгийн тайланд 5,652.5 сая төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байна. 2011 оноос хойш мал амьтнаар олгосон эргэн төлөх зээлд 7,350.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд 5,200.0 сая төгрөгийг эргүүлэн төлж 29.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бүртгэлээс үзэхэд: 2011 онд 632.5 сая төгрөгийн мал амьтад бүртгэгдэн 11.9 сая төгрөгийн мал хасагдаж, 620.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон. 2012 онд 11.6 сая төгрөгийн мал амьтад нэмэгдэж 666.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болжээ. 2013 онд 1,673.5 сая төгрөгийн мал амьтад нэмэгдэж, 2,430.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаа 2014 оны эхэнд 744.3 сая төгрөгийн мал амьтантай болж, 1,686.1 сая төгрөгөөр мал амьтадын дүн хий хасагдаж, 1,397.5 сая төгрөгийн мал амьтадыг нэмж бүртгэн жилийн эцэст 2,141.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болжээ.

Харин 2015 онд 57,394.0 сая төгрөгийн мал амьтан бүртгэлээс хасагдаж, 2,084.3 сая төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байжээ. 2016 онд ямар нэгэн хөдөлгөөн хийгдээгүй, 2017 онд 3,568.1 сая төгрөгөөр мал амьтадын дүнг өсгөн бүртгэж, 5,652.5 сая төгрөг болсон байна. 2018 онд ямар нэгэн хөдөлгөөн хийгдээгүй байна.

Тус санд байгаа мал амьтдын бүртгэл нь тоо толгой нас хүйсээр нь, сүргийн эргэлтийн бүртгэлийг хөтөлсөн нарийн бүртгэл байхгүй санхүүгийн тайланд, анх төсөл хэрэгжүүлэх хүрээнд ХХААХҮ-ийн сайдын тушаалаар /бодлогын гэрээ хийж/ олгосон мөнгөн зээлийн дүнгээр тусгадаг, гэрээнд 3-6 жилийн дараагаас эхлэн 30:30:40 гэсэн харьцаатайгаар анх бэлтгэсэн үүлдэр, угсааны, цэвэр цусны 18-22 сараас доошгүй насны, хээлтэгч, хээлтүүлэгчийг малаар хүлээн авч үнэлэн, дараагийн зээлдэгч нарт олгон, 3-5 жилийн дараагаас эхлэн анх олгосон толгойн тооны хээлтэгч, хээлтүүлэгчийг хүлээн авах нөхцөлтэй гэрээ хийгддэг байна.

Сүүлийн 7 жилийн баримтаас үзэхэд: “Гацуурт” ХХК-д төсөл хэрэгжүүлэхээр олгосон 2011 он олгосон 1,0 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг авч үзэхэд: 2011 оны 2011/07 тоот

гэрээнд зааснаар 6 жилийн дараа 200 толгой өсвөр насны хээлтэгч, хээлтүүлэгчээр төлөх нөхцөлтэй гэрээ нь 2015.07.15-нд 60 толгой хээлтэгч, хээлтүүлэгчээр төлөх, 2016.07.15-нд 60 толгой хээлтэгч, хээлтүүлэгч, эцсийн хугацаа 2017.07.15-нд 80 толгой хээлтэгч, хээлтүүлэгч авах ёстой байсан боловч, 2017 оны 10 дугаар сарын 10-нд 200 толгой “Ангус” үүлдэрийн үхрийг нэг дор хүлээн авч, 1,0 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг хааж, малыг бусад зээлдэгч нарт өгч гэрээ байгуулсан 1 удаагийн эргэлт хийсэн байна.

Харин 2011 онд Сүхбаатар аймагт барга, үзэмчин үүлдрийн хонь өсгөхөд зориулж, иргэн Б.Энхжаргалд нэг бүр нь 300,0 мянган төгрөгийн үнэ бүхий 1000 толгой хонийг худалдан авч өсгөхөд зориулж, 300.0 сая төгрөгийн зээл олгосон эргэн төлөлт хийгдээгүй байна.

Мөн 2008-2013 онд 36 аж ахуйн нэгж иргэнд 165 толгой бодон, мэгжийг худалдан авахад зориулж 108,590.0 мянган төгрөгийн зээл олгосон, 2007-2013 онд 16 иргэн аж ахуйн нэгжид 60 толгой өсвөр насны бух, гунжийг худалдан авахад 45,750.0 мянган төгрөгийн, 2009-2016 онуудад 77 иргэн аж ахуйн нэгжид 302 толгой хар тарлан, шар тарлан үүлдрийн 328 толгой үржлийн өсвөр насны бух гунж худалдан авч өсгөхөд зориулж нэг бүр нь 0.9-1.9 сая төгрөгийн үнэтэйгээр худалдан авахад зориулж, 536.1 сая төгрөгийн зээлийг тус тус олгожээ.

Мал аж ахуй эрхлэгчдэд 5 жилийн хугацаатай сүрэг сэлбэхэд дэмжлэг болохуйцаар Монгол орны цаг уурын онцлогт дасан зохицсоны дараа тухайн үүлдэр угсааны өсвөр, үржлийн насны үхрээр, адил тооны анх бэлтгэхэд олгосон дэмжлэгийн хэмжээнд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ хийгдсэн байна.

Мал хамгаалах санд үнийн дүнгээр бүртгэлтэй эхний ээлжинд олгосон хар тарлан, шар тарлан үүл үхрүүд нь зохих хэмжээгээр эргэлтэнд орсон бөгөөд малчдаар дамжаар нутгийн монгол үхэртэй эрлийзжин монголжсон байдалтай болсон гэж тус сангийн ажил хариуцсан ажилтан хэлж байлаа. Бүртгэл тодорхой бус байгаагаас эргэн төлөлт нь хангалтгүй, хугацаа нь хэтэрсэн байдалтай байна

Зөгийн аж ахуй хөгжүүлэх талаар

Зөгийн аж ахуйд зориулж 2014 оноос Улаанбаатар хот болон Булган, Дорнод, Сэлэнгэ, Орхон, Сүхбаатар, Төв, Увс аймгуудын 61 аж ахуйн нэгж байгууллага, иргэн, Эрдэм шинжилгээний болон Төрийн бус байгууллагад 800 бүл буюу 800 хайрцагийг нэг бүрийг нь 12.8-32.0 сая төгрөгөөр нийтдээ 1,094.6 сая төгрөгөөр худалдан авахад зарцуулжээ. Эргэн төлөлтийн хугацаа сунгагдсан байна.

Гахайн аж ахуйн талаар

Мал хамгаалах сангаа 2008 онд 10 аж ахуйн нэгж иргэнд нэг бүр нь 800.0 мянган төгрөгийн үнэ бүхий 10 бодонг 8.0 сая төгрөгөөр, 2009 онд ХУД-ийн иргэн Д.Ариунбатад 7 мэгжийг 4.4 сая төгрөгөөр, 1 бодонг 800,0 мянган төгрөгөөр, 2012 онд 4 иргэнд 4 бодонг 3.2 сая төгрөгөөр, 2008 онд 10 аж ахуйн нэгж иргэнд 100 мэгжийг 64.5 сая төгрөгөөр, 2012 онд 5 аж ахуйн нэгж иргэнд 29 мэгжийг 18.6 сая төгрөгөөр, 2013 онд ХУД-ийн 2 иргэнд 14 мэгжийг 9.1 сая төгрөгөөр тус тус худалдан авч төслийг дэмжсэн боловч эргэн төлөлт хангалтгүй байна.

Илэрсэн зөрчлийн талаар:

- 1. ОХУ-аас малын тэжээл импортлон оруулж, борлуулахаар олгосон хүүгүй зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс маргаан үүссэн, зарим зээлдэгчид зээлээ төлж эхлээгүй, хаяг байршилдаа ч байхгүй эрэн сурвалжлах байдал үүсчээ.**

Малын тэжээлл импортлох зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлтийг 2018 оны 12 дугаар сарын 06-ны байдлаар авч үзэхэд 40.0 тэрбум төгрөгийн зээл авсан 34 компаниас 31 компани нь 18,258,712.1 мянган төгрөгийн зээлийг эргэн төлсөн бөгөөд одоо 23 компаниас 22,886,367.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд Мал хамгаалах сангаас гэрээнд зааснаар гүйцэтгээгүй /төлөлт хийгээгүй зээлийн үлдэгдэл/ үнийн дүнгээс алданги тооцож, зээлдэгчийн харъяалах шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байна.

Энэ оны 12 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар зээлийн эргэн төлөлт 45.6 хувьтай байгаа бөгөөд зээлийг эргэн төлүүлэх талаар сангийн ажилтнууд төлөвлөгөө гарган хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж байна.

Гэрээ ёсоор зээлийг төлж дуусах хугацаа 3 сар гаруйгаар өнгөрсөн байх тул, зээлээ төлөхгүй байгаа зээлдэгч нараас гэрээнд заасан ёсоор, алданги тооцон шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байгаа бөгөөд зарим зээлдэгчийн шүүх хурал болж шийдвэр нь гарсан, зарим зээлдэгчийн шүүх хурлын тов зарлагдсан байдалтай байна.

Нийт 34 зээлдэгчээс одоогийн байдлаар 10,830.0 сая төгрөгийн зээл авсан 12 компани зээлээ бүрэн төлж барагдуулсан, харин “Биохэлф монголиа” ХХК 900.0 сая төгрөгийн, “Туртелком” ХХК 1.0 тэрбум төгрөгийн, “Галин интернейшнл” ХХК 1,1 тэрбум төгрөгийн зээлийг тус тус авсан боловч өнөөг болтол огт төлж эхлээгүй байна.

- 2. “Гацуурт” ХХК нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр авсан зээлээ төлөхгүй, хугацаа хоцроож, гэрээний үүргээ зөрчиж, улсад хохирол учруулсаар байна.**

ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Мал хамгаалах сан, “Гацуурт” ХХК-тай байгуулсан “ЭМААХДХ”- 2011/07 тоот гэрээгээ дүгнэж, акт үйлдээгүй нь 2015, 2016 онуудад гэрээний хэрэгжилт хангагдаагүй, зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

ХХААХҮ-ийн сайдын 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/102 дугаар тушаалыг үндэслэн махны цэвэр үүлдрийн үхэр импортолж, үржлийн аж ахуй эрхлэх төслийг хэрэгжүүлэхэд зээлийн гэрээгээр зээлдэгч 1.0 тэрбум төгрөгийг тодорхой нас хүйсний өсвөр насны хээлтэгч, хээлтүүлэгчээр 6 жилийн хугацаанд 200 толгой үхрээр төлнө гэсэн нь нэг үхрийн өртөг 5.0 сая орчим төгрөг байна.

Зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүйгээс үүссэн алданги нь 2017 онд 21.9 сая төгрөг, 2016 онд 11.0 сая төгрөг орчим нийт 32.9 сая төгрөг байхаар үүнийг үхэрт шилжүүлэн тооцвол 6 үхрийг нэмж авахаар байсан боловч алданги тооцоогүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Үнэ тогтоох, хуваарь батлах тухай А/135 тоот тушаалаар “Гацуурт” ХХК-иас зээлийн эргэн төлбөрт 200 толгой “Ангус” үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгч үхрийг нэг бүрийг 5.0 сая төгрөгөөр үнэлэн хүлээн авч, үүссэн алдангийг чөлөөлсөн шийдвэр гаргажээ.

Дээрхи тушаалын дагуу төсөл хэрэгжүүлэгчээс анхны гэрээнд заасан цэвэр цусны “Лимузин” үүлдрийн өсвөр насны үхэр авах заалтыг зөрчиж, “Ангус” үүлдрийн болон монгол үхэртэй эрлийзжсэн өсвөр насны үхэр болж өөрчлөгдсөн, энэ тохиолдолд үнэлгээний зөрүү гарах ёстойг мөн харгалзан үзэлгүйгээр 100 толгой хээлтүүлэгч, 100 толгой хээлтэгч нийт 200 толгой үхрийг авч 6 аймаг, Малын удмын сангийн үндэсний төв болон Мал хамгаалах санд тус тус хуваарилан 1.0 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг 2017 оны төгсгөлөөр хаасан байна.

Мөн 2013 онд 2.0 тэрбум төгрөгийн зээлийг нэмж олгон малаар төлөлт хийх гэрээтэй ажиллаж байгаа бөгөөд 2013 онд байгуулсан гэрээ ёсоор 2017 оны 7 дугаар сард 52 толгой, 2018 оны 7 сард мөн 52 толгой, нийт 104 толгой цэвэр цусны хээлтэгч, хээлтүүлэгчийг хүлээлгэн өгсөн байх ёстой боловч, гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж малаа хүлээлгэн өгөөгүй өнөөг хүрсэн байна.

3. Банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан 2005 онд олгосон зээлийн 47.2 хувийг эргүүлэн төлүүлж авалгүй 13 жил болжээ.

2005 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “Зээлийн үйлчилгээ үзүүлэх тухай ЗҮ-2005/1 дугаартай гэрээг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захирал Ч.Пэрэнлэй, нөгөө талаас 9015001008 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5018218 тоот регистрийн дугаартай “Праймлайнс” ББСБ-ын Гүйцэтгэх захирал Х.Гансүх нар гэрээ байгуулж, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 169 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, Зээлийн үйлчилгээ үзүүлэх гэрээг 2005 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 2007 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 1 жил, 6 сарын хугацаагаар байгуулжээ.

Гэрээний ерөнхий нөхцөлийн 1.4-д Гэрээний хугацаа дуусмагц эх үүсвэрийг буцаан Мал хамгаалах санд шилжүүлж, төлбөрийн тооцоогүй болж, хоёр тал гэрээг дүгнэснээр гэрээ дуусгавар болно. “Сангийн хүлээх үүрэг” гэсэн хоёр дахь хэсгийн 2.1-д Энэхүү гэрээ хийснээс хойш ажлын гурван өдөрт багтаан 187.0 сая төгрөгийг ББСБ-ын нэхэмжлэлийг үндэслэн Голомт банк дахь 110 283 4958 тоот дансанд шилжүүлж, төслүүдийн хамт өгөхөөр, 2.4-д Сан зээлийн хүүг өгөхгүй бөгөөд хүүг ББСБ-ын үйлчилгээний зардал болон зээлийн эрсдэлд зориулан олгоно.

Гэрээний гурав дахь хэсгийн 3.4-д Зээлийн хүү жилийн 12 хувь байх бөгөөд уг хүүг ББСБ авна, Мөн зээлдэгчдээс төслийн зээлийн дүнгийн нэг хувиар үйлчилгээний шимтгэл авна.

Мөн гурав дахь хэсгийн 3.13-д Төлөгдсөн зээлийн хөрөнгийг улирал бүрийн дараа сангийн 10-ны дотор сан шилжүүлж байх ба төслийн хугацаа 2007 оны 7 дугаар сарын 01-нээр дуусахад төслийн үлдэгдэл эх үүсвэрийг төсөл хэрэгжүүлэгчээс зээл төлсөн, төлөөгүйг үл харгалзан мал хамгаалах сангийн Төрийн сан дахь 900019040 тоот дансанд бүрэн шилжүүлж өгнө. 3.14-д Зээлийг олгох, төслийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, зээлийг буцаан төлүүлэх болон төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүхий л зардал, зээлийн

эрсдэлийг бүрэн хариуцана. Гэрээний дөрөв дэх хэсгийн 4.3-д Зээлийн эх үүсвэрийг гэрээний 3.10-д заасан хугацаанд эргэн төлөөгүй тохиолдолд, төлөгдөөгүй үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.3 хувийн алданги тооцно гэжээ.

Гэтэл энэхүү банк бус санхүүгийн байгууллагатай хийсэн гэрээний үр дүнг дүгнэж актаар баталгаажуулаагүй, тус санд зээлдэгчидтэй хийсэн зээлийн гэрээний хувь болон зээл олгосон баримтууд байхгүй тул, зээлдэгч бүрээр нарийвчлан шалгаж дүгнэлт хийх боломжгүй болсон байна. Энэхүү зээлийг олгосноос хойш 13 жил болсон бөгөөд 2007 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас “Мал хамгаалах сан”-ийн дансанд “Праймланс” ББСБ-аас “ЭМААХДХ”-өөс олгосон зээлийн авлагаар 166.0 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Үүнээс үзэхэд 21.0 сая төгрөгийг хэдийд хаана төлсөн нь тодорхойгүй байгаа бөгөөд Шүүхийн шийдвэрээр 77.7 сая төгрөгийг төлүүлж, 2018 оны 11 дүгээр сарын 12-ны байдлаар 88.2 сая төгрөгийн авлагатай байна.

4. Малын тэжээл импортлох зориулалтаар олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс “Мал хамгаалах сан” улсын төсөвт 40.0 тэрбум төгрөгийн өглөгтэй байна.

Малын тэжээл бэлтгэн нийлүүлэх зээлд хамрагдсан 27 компанийн ихэнх нь 300.0 саяас -1.0 тэрбум төгрөгийн зээл авсан байхад “Арованно” ХХК, “Хөвсгөл Алтан дуулга” ХХК-иуд тус бүр 5.0 тэрбум төгрөгийн, “Чансаа Хан Хөхий” холдинг ХХК 3.0 тэрбум төгрөгийн, “ЧМТО” ХХК, “Жи Өү Ти Ти” ХХК, “Од групп” “Милл хаус” ХХК-иуд тус бүр 2.0 тэрбум төгрөгийн, “Жинст транс” ХХК 1.3 тэрбум төгрөгийн хүүгүй зээлийг тус тус авсан байна.

Зээлийн эргэн төлөлтийг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар авч үзэхэд 40.0 тэрбум төгрөгийн зээл авсан 34 компаниас 31 компани нь 18.3 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлсөн бөгөөд одоо 23 компаниас 22.9 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд “Мал хамгаалах сан” гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй /төлөлт хийгээгүй зээлийн үлдэгдэл/ үнийн дүнгээс алданги тооцож, зээлдэгчийн харъяалах шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байна.

Энэ оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар зээлийн эргэн төлөлт 45.6 хувьтай байгаа бөгөөд Нийт 34 зээлдэгчээс 10.8 тэрбум төгрөгийн зээл авсан 12 компани зээлээ бүрэн төлсөн, “Биохэлф монголиа” ХХК 900.0 сая төгрөгийн, “Туртелком” ХХК 1.0 тэрбум төгрөгийн, “Галин интернейшнл” ХХК 1.1 тэрбум төгрөгийн зээлийг авсан боловч огт төлж эхлээгүй байна. Мал хамгаалах сан улсын төсөвт 40.0 тэрбум төгрөгийн зээлийн өглөгтэй байна.

5. Мал хамгаалах сангаас олгодог эргэлтийн зээлийн журам боловсрууж мөрдөөгүй зарим аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зээлийг дахин давтан олгодог, авсан зээлээ төлөөгүй байхад зээл олгосон зэрэг зөрчил илэрч байна. /дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулсныг хавсаргав.

Тус сангаас 2003-2018 онуудад давхардсан тоогоор нийтдээ 79 байгууллага, ААН, иргэнд 8.3 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Үүнээс хугацаандаа төлөөгүй 37 ААНБ-ын 5.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

6. Мал амьтдын бүртгэл, зээлийн эргэн төлөлт хангалтгүй, данс бүртгэлд авлагаар тусгаагүй, 556.8 сая төгрөгийн мал, амьтадыг дараагийн зээлдэгчид олгоогүйгээс үндсэн зорилт хэрэгжихэд хүндрэл учруулж байна.

Мал хамгаалах сангийн 2017 оны санхүүгийн тайланд 5,652.5 сая төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байгаагаас 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 15 толгой бодон, 150 толгой мэж, 5 толгой бух, 55 толгой гунж, 83 толгой хар тарлан үхэр, 1 толгой шар тарлан үүлдрийн бух, 94 толгой шар тарлан үүлдрийн өсвөр үхэр, 145 толгой шар тарлан үхэр, 800 бүл буюу 800 хайрцаг зөгий бүртгэлтэй байна.

Тус санд байгаа мал амьдыг тоо толгой нас хүйсээр, сүргийн эргэлтийн бүртгэлийг хөтөлсөн нарийн бүртгэл байхгүй, санхүүгийн тайланд анх төсөл хэрэгжүүлэх хүрээнд ХХААХҮ-ийн сайдын тушаалаар /бодлогын гэрээ хийж/ олгосон мөнгөн зээлийн дүнгээр тусгадаг, гэрээнд 3-6 жилийн дараагаас эхлэн 30:30:40 гэсэн харьцаатайгаар анх бэлтгэсэн үүлдэр, угсааны, цэвэр цусны 18-22 сараас доошгүй насны, хээлтэгч, хээлтүүлэгчийг малаар хүлээн авч үнэлэн дараагийн зээлдэгч нарт олгох нөхцөлтэй гэрээ хийгддэг боловч гэрээ дүгнэсэн материал дутуу, ихэнх мал, амьтадын бүртгэл анх олгосоноос хойш хөдөлгөөн хийгдээгүй байгаа нь шилмэл үүлдрийн мал амьтаар сүргийн эргэлт хийх зорилт хангагдаж чадаагүй гэж үзэхээр байна.

Сангаас зээл авсан зарим зээлдэгч нарт тодорхой судалгаа, шалгуурыг баримтлаагүй, захирлын тушаал, шийдвэр гараагүй байхад зээл олгосон, мөн зээлдэгчдэд өмнөх зээлээ төлөөгүй буюу зээл төлөх хугацаа нь хэтэрсэн байхад, дахин зээл олгосон зэрэг зөрчлийг гаргасан байна.

ДҮГНЭЛТ:

Мал хамгаалах сан нь шалгалтад хамрагдсан хугацааны баримтаас үзэхэд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, төслүүдэд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, иргэдийг холбож зуучлах үүргийг ханган биелүүлэх, тавьсан зорилтоо хэрэгжүүлж ажилласан байна.

Тус зорилгын хүрээнд төрөөс хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа бодлогын хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгөөр иргэн, аж ахуйн нэгжид олгодог төрөл бүрийн дэмжлэгүүдийг олгох, эргэн төвлөрүүлэх, хяналт тавих, үр дүнг тооцож, тайлагнах үйл ажиллагааг холбогдох журам, зааврын дагуу явуулжээ.

Тус сангийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, түүний эмх цэгц, анхан шатны баримтын бүрдүүлэлт нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу зохих түвшинд зохион байгуулагдаж хийгдсэн байна.

Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж тооллого бүртгэлийн явуулах, шинээр хөрөнгө авах, хуучныг актлан асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэжээ.

Гэвч мал аж ахуйн салбарт төрийн бодлогоор авч хэрэгжүүлсэн томоохон төсөл, хөтөлбөр, зээл тусламж, хөрөнгө оруулалтын үр дүнг нэгтгэн дүгнэж, мэдээлэх, гэрээний хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж зориулалтын

дагуу ашиглуулж, гэрээг хамтран дүгнэж, зээлийг эргэн төлүүлэх, гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй, хугацааг хэтрүүлсэн, зөрчил үүссэн тохиолдолд торгууль алданги хүлээлгэх зэрэг гэрээний хөшүүргийг хэрэглээгүй байгаа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Мал хамгаалах сангийн тухайн үеийн удирдлагууд, хариуцсан албан тушаалтнуудын ажлын хариуцлага, ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой байна гэж дүгнэж байна.

Мал хамгаалах сангаас олгож буй жижиг зээл болон зээлийн эргэн төлөлтөөс мөнгөн хэлбэрээр болон мал, амьтдаар олгож буй зээлийн харилцааг зохицуулах журам боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай байна. Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолоор “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам”-ыг баталж хэрэгжүүлэхдээ өмнө нь мөрдөж байсан Сангийн болон Хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар баталсан журам хүчингүй болсон байна.

Мал хамгаалах сангаас өмнөх онуудад олгосон зээлийн өр төлбөрийн судалгааг нарийвчлан насжилтаар гаргаж судлах, төлөхгүй байгаа шалтгааныг тогтоон хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж, барагдуулах шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах,

Зээлийн чанарын ангилалыг гаргах, зээлийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод “зээлийн хуваарьт төлбөрийг 3 сараас дээш хугацаагаар дээш хугацаагаар хэтрүүлсэн өртэй этгээдийн бүртгэлийг хөтөлж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд тухай бүрт нь оруулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байгаа нь ирээдүйд сангийн хөрөнгийн удирдлагыг эрсдэлд оруулах нөхцөлийг бүрдүүлэхээр байгаад анхаарч ажиллах, Иймд Монгол банкны Ерөнхийлөгч, Сайдын сайдын хамтарсан 2016 оны А/336/400, 2017 оны А/193/228 дугаар тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-ын дагуу активыг ангилахад хүндрэлтэй байвал, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон зээл, дэмжлэгийн чанарыг ангилах, бүртгэх журам, зааврыг боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Мал хамгаалах сангаас олгож байгаа зээлийг зээлдэгч нар зориулалтын дагуу ашиглаж байгаад хяналт тавьдаггүй, зөвхөн зээлийг бүртгэх, эргэн төлөлтийн тооцоог нийлэх зэргээр хязгаарлаж, зээлийн гэрээнд заасан ерөнхий болон тусгай шаардлагуудыг хангаж байгаа эсэх, гэрээний хэрэгжилтийг дүгнэх, алданги торгууль ногдуулах зэрэг гэрээний хөшүүргийг ашиглахгүй байгааг анхааралдаа авч ажиллах шаардлагатай байна.

Цаашид анхаарах асуудлуудын талаарх зөвлөмж:

- АТААСҮ ХХК-тай байгуулсан “Альпин” үүлдвэрийн ямаа үржүүлэх төслийн 450 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн асуудал удааширч хүндрэлтэй байгаад анхаарч, хугацаа сунгах, цаашид зээлийг боломжтой хэлбэрүүдээр төлүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
- “Гацуурт” ХХК-тай 2013 онд байгуулсан 2,0 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөөс 1,200.0 сая төгрөгийн зээлийг эргэн төлсөн байх, гэрээний үүрэг хангагдаагүй хугацаа хэтэрсэн байх тул энэ асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх.

- 2003-2006 онд “Шилмэл хээлтүүлэгч дэд хөтөлбөр”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдэл 359.8 сая төгрөг байна. Энэхүү зээлийн хөөн хэлэлцэх хугацаа нь дуусч шүүхийн байгууллагад хандах боломжгүй болсон байх тул, хөөн хэлэлцэх хугацааг сэргээлгэх, зээлийг төлүүлж улсыг хохиролгүй болгох талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.
- Хөнгөлттэй нөхцлөөр ХАА-н техник, тоног төхөөрөмжийг иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлсэн техник, тоног төхөөрөмжүүдийг түрээслэх хугацаанд анхны өртгийн 50 хувийн үнийг ч нөхөхгүй, доогуур үнээр түрээслэж байгааг өөрчлөн, лизенгээр худалддаг хэлбэрт шилжүүлэх асуудлыг судлан, эрх бүхий дээд байгууллагын зөвшөөрлийг авч нэгдсэн нэг бодлого баримтлан ажиллах;
- Тоног, төхөөрөмжийг худалдан авч нийлүүлж байгаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох газар албад, Мал хамгаалах сангийн зүгээс малчид, фермерүүдээс шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн захиалгыг урьдчилан авч, зах зээлийн үнээс хямд өртөгтэй, чанар стандартын шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулалт хийж, худалдан авч нийлүүлж байх талаар салбарын яаманд мэдэгдэх, танилцуулга хүргүүлэх арга хэмжээ авах;
- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглуулах, гэрээнд заасан хугацаанд эргэн төлүүлэх талаар онцгой анхаарч, гэрээний үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, тогтоосон хугацаанд нь дүгнэж хэвшүүлэх, гэрээний төрөл бүрийн хөшүүргийг оновчтой ашиглахын зэрэгцээ салбарын яам, Мал хамгаалах сангийн ажилтнуудын ажлын уялдааг холбоог сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах;
- Тус сангаас зээл авсан зарим зээлдэгч нарт тодорхой судалгаа, шалгуурыг баримтлаагүй, захирлын тушаал, шийдвэр гараагүй байхад зээл олгосон, мөн зээлдэгчидэд өмнөх зээлээ төлөөгүй буюу зээл төлөх хугацаа нь хэтэрсэн байхад, дахин зээл олгосон зэрэг зөрчлийг гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчлийг таслан зогсоох.

Мал хамгаалах сангийн 2011-2018 оны 3 улирлын байдлаарх санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн жагсаалт:

/сая.төгрөг/

№	Зөрчлийн утга	Хариуцагчийн нэр	Зөрчлийн дүн /сая төгрөг/	Тайлбар
1	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/149, А/161 тоот тушаалаар Малын тэжээл дотооддоо үйлдвэрлэх болон ОХУ-аас импортоор оруулж, борлуулах аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж, улсын төсвөөс хүүгүй зээл олгосон, зээлийг эргүүлэн төлөх хугацаа 2018 оны 8 дугаар сарын 01-нээр дууссан	Зээлдэгч компаниуд “Мал хамгаалах сан”	21,741.3	Нийт 34 аж ахуйн нэгжид 40.0 тэрбум төгрөгийн зээлийг улсын төсвөөс олгосон боловч, 18,258.7 сая төгрөгийг 2018.12.06-ны байдлаар төлснийг төсөвт төвлөрүүлсэн, одоо 21,741.3 сая төгрөгийг 22 компани төлнө. Харин “Биохэлф монголиа” ХХК 900.0 сая төгрөг, “Туртелком” ХХК 1,000.0 сая төгрөг, “Галин интернейшнль” ХХК 1,100.0 сая

	боловч ихэнх аж ахуйн нэгжүүд зээлээ төлөөгүй тул алданги тооцон шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.			төгрөгийн зээлийг авсан боловч огт төлж эхлээгүй байна.
2	“Гацуурт” ХХК нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр авсан зээлээ төлөхгүй, хугацаа хоцроож, гэрээний үүргээ зөрчиж, улсад хохирол учруулж байна.	Гацуурт ХХК	1,200.0	Нийт 2.0 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжүүлэх нөхцөлтэй зээлийг авсан боловч 2017, 2018 онуудад малаар эргүүлэн төлөх гэрээний үүрэг хэрэгжээгүй, гэрээний заалтыг зөрчиж байна.
3	Банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан 2005 онд олгосон зээлийн 47.2 хувийг эргүүлэн төлүүлж авалгүй 13 жил болсон.	Праймланс ББСБ	88.2	МХСанд шилжсэн 166.0 сая төгрөгөөс шүүхийн шийдвэрээр 77.7 сая төгрөгийг төлүүлж, 88.2 сая төгрөгийн авлагатай байна.
4	Мал хамгаалах сангаас 2012-2018 онуудад малчид, мал бүхий иргэд фермерүүд, аймгуудын ХААГ, Мал эмнэлэг, үржлийн албадад борлуулсан техник, тоног төхөөрөмжийн үнийг төлөөгүй байна.	Мал хамгаалах сан, техник, тоног төхөөрөмж худалдан авагчид	1,067.5	Нийтдээ 2012-2018 онуудад 562 ширхэг 6,129.1 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдаж, 5,061.6 сая төгрөгийг төлж, 1,067.5 сая төгрөгийг төлүүлж аваагүй байна.
5	Мал хамгаалах сангаас олгодог эргэлтийн зээлийн журам боловсрууж мөрдөөгүй, зарим аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зээлийн дахин давтан олгодог, мөн авсан зээлээ төлөөгүй байхад зээл олгосон зэрэг зөрчил илэрч байна.	Мал хамгаалах сан, зээл авсан ААНБ, иргэд ТББ	5,300.0	Жагсаалтыг гарган шалгалтын тайланд хавсаргав.
6	Түрээслүүлсэн техник, тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн.	Түрээслэгч ААНБ, иргэд	529.8	Түрээсийн төлбөрийн орлого 2015 онд 85.8 сая төгрөг, 2016 онд 124.8 сая төгрөг, 2017 онд 158.7 сая төгрөг, 2018 онд 160.5 сая төгрөг төвлөрөөгүй байна.
Нийт дүн			29,926.8	

**САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН ГАЗАР**